



---

# ЦАГ АШИГЛАЛТЫН СУДАЛГАА

---

Үндсэн тайлан



УЛААНБААТАР ХОТ  
2020 ОН



Хянасан:

Ч.Баянчимэг	ҮСХ-ны дэд дарга
А.Амарбал	ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга
А.Дэмбэрэл	ҮСХ-ны Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газрын дарга

Бичиж боловсруулсан:

С.Тодгэрэл	ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын статистикч
Т.Алтанцэцэг	ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын статистикч
Д.Мэндбаяр	ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын судалгааны ажилтан
Э.Золзаяа	ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын судалгааны ажилтан



## АГУУЛГА

<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b> .....	1
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b> .....	5
<b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ</b> .....	6
<b>ӨМНӨХ ҮГ</b> .....	7
<b>СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН</b> .....	8
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТАНИЛЦУУЛГА</b> .....	11
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b> .	13
А. Түүврийн загвар .....	13
Б. Судалгааны асуулга.....	14
В. Судалгаанд ашигласан ангилал .....	15
Г. Мэдээлэл цуглуулах арга .....	15
Д. Сургалт .....	15
Е. Мэдээлэл цуглуулалт .....	16
Ё. Мэдээлэл боловсруулалт.....	16
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ХАМРАЛТ, СУДАЛГААНД</b>	
<b>ХАМРАГДАГЧДЫН ШИНЖ БАЙДАЛ</b> .....	17
А. Судалгааны хамралт .....	17
Б. Судалгаанд хамрагдсан өрхийн үзүүлэлтүүд.....	17
В. Судалгаанд хамрагдсан хүн амын үзүүлэлтүүд.....	24
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ХҮН АМЫН ЦАГ АШИГЛАЛТ</b> .....	31
А. Ерөнхий төлөв.....	31
Б. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа .....	55
В. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа .....	62
Г. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа.....	75
<b>Хавсралт А. Хүн амын цаг ашиглалтын байдал, насны бүлэг болон бусад сонгосон</b>	
<b>үзүүлэлтээр</b> .....	86
1. 12-17 насны хүүхдийн цаг ашиглалт .....	86
2. 18-24 насны залуучуудын цаг ашиглалт.....	88
3. 25-39 насны хүн амын цаг ашиглалт.....	98
4. 40-59 насны хүн амын цаг ашиглалт.....	114
5. 60, түүнээс дээш насны ахмадуудын цаг ашиглалт.....	130
<b>Хавсралт Б. Судалгаанд оролцогчдын нэрс</b> .....	142
<b>Хавсралт В. Цаг ашиглалтын статистикт зориулсан үйл ажиллагааны ангилал</b>	143
<b>Хавсралт Г. Асуулгын хуудас</b> .....	149

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2А. 1. Судалгааны түүвэрт сонгогдсон өрхийн тоо, бүс, аймгаар, 2019 он.....	14
Хүснэгт 3А. 1. Судалгаанд хамрагдсан өрхийн тоо, өдрийн тэмдэглэл хөтөлсөн 12, түүнээс дээш насны болон 5 хүртэлх насны хүүхдийн асуулгад хамрагдсан хүн амын тоо, хамрагдалтын түвшин, хот, хөдөө, бүсээр, Монгол Улс, 2019 он.....	17
Хүснэгт 3Б. 1. Судалгаанд хамрагдсан өрхийн эзлэх хувь, сонгосон үзүүлэлтээр, Монгол Улс, 2019 он .....	19
Хүснэгт 3Б. 2. Өрхийн сууцны төрөл болон цахилгаан эрчим хүчний болон халаалтын эх үүсвэр, хот, хөдөө болон бүсээр, дүнд эзлэх хувиар, Монгол Улс, 2019 он .....	21
Хүснэгт 3Б. 3. Өрхийн эзэмшдэг эд зүйлс болон сууцны өмчлөл, хот, хөдөө, болон бүсээр, дүнд эзлэх хувиар, Монгол Улс 2019 он .....	22
Хүснэгт 3Б. 4. Өрхийн ундны усны эх үүсвэр, ундны ус авахад зарцуулдаг хугацаа, хот, хөдөө болон бүсээр, дүнд эзлэх хувиар, Монгол Улс 2019 он .....	23
Хүснэгт 3Б. 5. Өрхийн ариун цэврийн байгууламжийн төрөл болон ариун цэврийн байгууламжаа бусадтай хамтран хэрэглэдэг эсэх, хот, хөдөө болон бүсээр, дүнд эзлэх хувиар, Монгол Улс 2019 он .....	24
Хүснэгт 3В. 1. Өрхөд амьдардаг хүн амын эзлэх хувь, 5 насны бүлэг, хүүхэд (0-11 насны), өсвөр насныхан (12-17 насны) болон насанд хүрсэн (18, түүнээс дээш насны) хүн амын эзлэх хувь, хүйсээр, Монгол Улс, 2019 он .....	24
Хүснэгт 3В. 2. Өдрийн тэмдэглэл хөтөлсөн 12, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь, сонгосон үзүүлэлтээр, Монгол Улс, 2019 он.....	25
Хүснэгт 3В. 3. Өдрийн тэмдэглэл хөтөлсөн 12, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь, байршил, хүйс, гараг, тэмдэглэл хөтөлсөн өдрийн тоогоор, Монгол Улс, 2019 он.....	26
Хүснэгт 3В. 4. Өдрийн тэмдэглэл хөтөлсөн 12, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь, насны бүлэг, хүйс, гараг, тэмдэглэл хөтөлсөн өдрийн тоогоор, Монгол Улс, 2019 он.....	27
Хүснэгт 3В. 5. Өдрийн тэмдэглэл хөтөлсөн 12, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэх, үйлдлийн чадварын хүндрэлийн төрлөөр, хот, хөдөө, хүйсээр, Монгол Улс, 2019 он .....	28
Хүснэгт 3В. 6. Өдрийн тэмдэглэл хөтөлсөн 15, түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлдэг хүн амын эзлэх хувь, хөдөлмөр эрхлэлтийн байдал болон ажил мэргэжлийн ангиллаар, мөн сүүлийн 7 хоногт үндсэн ажилдаа зарцуулсан дундаж хугацаа, хот, хөдөө, хүйсээр, Монгол Улс, 2019 он.....	29
Хүснэгт 3В. 7. Өдрийн тэмдэглэл хөтөлсөн 15, түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлдэг хүн амын эзлэх хувь, ажиллаж буй эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, хот, хөдөө, хүйсээр, Монгол Улс, 2019 он .....	30
Хүснэгт 4А. 1. Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хот хөдөөгөөр, Монгол Улс, 2019 он.....	34
Хүснэгт 4А. 2. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан минут, хүйсээр, Монгол Улс, 2007, 2011, 2015, 2019 он.....	37

Хүснэгт 4А. 3. Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, хүйс, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он.....	38
Хүснэгт 4А. 4. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, насны бүлгээр, минутаар, Монгол Улс, 2019 он.....	39
Хүснэгт 4А. 5. Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, насны бүлэг, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он.....	40
Хүснэгт 4А. 6. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшнээр, минутаар, Монгол Улс, 2019 он.....	42
Хүснэгт 4А. 7. Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйс, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он.....	43
Хүснэгт 4А. 8. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, хөдөлмөр эхэлдэг эсэхээр, хүйсээр, минутаар, Монгол Улс, 2019 он.....	45
Хүснэгт 4А. 9. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, хөдөлмөр эхэлдэг эсэхээр, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он.....	46
Хүснэгт 4А. 10. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, хүйсээр, минутаар, Монгол Улс, 2019 он.....	48
Хүснэгт 4А. 11. Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, хүйсээр, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он.....	49
Хүснэгт 4А. 12. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, гэрлэлтийн байдал, хүйсээр, минутаар, Монгол улс, 2019 он.....	51
Хүснэгт 4А. 13. Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, гэрлэлтийн байдал, хүйс, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он.....	52
Хүснэгт 4А. 14. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, хүүхэдтэй эсэхээр, хамт амьдардаг 16 хүртэлх насны хүүхдийн тоогоор, хүйсээр, минутаар, Монгол Улс, 2019 он.....	54

Хүснэгт 4А. 15. Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, хүүхэдтэй эсэхээр, хамт амьдардаг 16 хүртэлх насны хүүхдийн тоогоор, хүйсээр, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он .....	55
Хүснэгт 4Б. 1. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй хөдөлмөрт зарцуулсан дундаж хугацаа, хүйс, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он .....	57
Хүснэгт 4Б. 2. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй хөдөлмөрт зарцуулсан дундаж хугацаа, насны бүлгээр, минутаар, Монгол Улс, 2019 он .....	58
Хүснэгт 4Б. 3. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд өдөрт зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшнээр, минутаар, Монгол Улс, 2019 он.....	59
Хүснэгт 4Б. 4. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, хөдөлмөр эхэлдэг эсэхээр, хүйсээр, минутаар, Монгол Улс, 2019 он.....	61
Хүснэгт 4Б. 5. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, хүйсээр, минутаар, Монгол Улс, 2019 он.....	62
Хүснэгт 4В. 1. Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын гэрийн ажилд болон өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад зарцуулж буй дундаж хугацаа, сонгосон шинж байдлаар, минутаар, Монгол Улс, 2019 он.....	64
Хүснэгт 4В. 2. Долоо хоногийн, ажлын болон амралтын 1 өдөрт хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан дундаж хугацаа, хүйс, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он .....	66
Хүснэгт 4В. 3. Долоо хоногийн, ажлын болон амралтын 1 өдөрт хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан дундаж хугацаа, насны бүлгээр, минутаар, Монгол Улс, 2019 он ..	68
Хүснэгт 4В. 4. Долоо хоногийн, ажлын болон амралтын 1 өдөрт хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшнээр, минутаар, Монгол Улс, 2019 он.....	69
Хүснэгт 4В. 5. Долоо хоногийн, ажлын болон амралтын 1 өдөрт хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан дундаж хугацаа, хүйс, хөдөлмөр эрхэлдэг эсэхээр, минутаар, Монгол Улс, 2019 он.....	70
Хүснэгт 4В. 6. Долоо хоногийн, ажлын болон амралтын 1 өдөрт хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан дундаж хугацаа, хүйс, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, минутаар, Монгол Улс, 2019 он .....	72
Хүснэгт 4В. 7. Долоо хоногийн, ажлын болон амралтын 1 өдөрт хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан дундаж хугацаа, хүйс, гэрлэлтийн байдлаар, минутаар, Монгол Улс, 2019 он .....	73
Хүснэгт 4В. 8. Долоо хоногийн, ажлын болон амралтын 1 өдөрт хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан дундаж хугацаа, хүйс, хүүхэдтэй эсэхээр, хүүхэдтэй бол хамт амьдардаг 16 хүртэлх насны хүүхдийн тоогоор, минутаар, Монгол Улс, 2019 он.....	75



Хүснэгт 4Г. 1. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, хүйсээр, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он.....	77
Хүснэгт 4Г. 2. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, насны бүлгээр, минутаар, Монгол Улс, 2019 он ..	79
Хүснэгт 4Г. 3. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшингээр, минутаар, Монгол Улс, 2019 он .....	81
Хүснэгт 4Г. 4. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, хөдөлмөр эрхэлдэг эсэхээр <sup>1</sup> , хүйсээр, минутаар, Монгол Улс, 2019 он .....	83
Хүснэгт 4Г. 5. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, хүйсээр, минутаар, Монгол Улс, 2019 он.....	85

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 3Б. 1. Өрхийн амьдарч буй сууцны төрөл, дүнд эзлэх хувиар, Монгол Улс, 2019 он.....	20
Зураг 4А. 1. Долоо хоногийн 1 өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын цаг ашиглалтын ерөнхий дүр зураг, үйл ажиллагаа тус бүрээр, түүнд зарцуулсан минутаар, 2019 он.....	32
Зураг 4А. 2. 12, түүнээс дээш насны хүн амын 1 өдрийн амьдралын хэв маяг, 24 цагаар, үйл ажиллагаагаар, дүнд эзлэх хувиар, Монгол Улс, 2019 он.....	33
Зураг 4А. 3. Ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, Монгол Улс, 2019 он.....	35
Зураг 4А. 4. Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, Монгол Улс, 2007, 2011, 2015, 2019 он.....	36
Зураг 4А. 5. Долоо хоногийн 1 өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, насны бүлэг, хүйсээр, дүнд эзлэх хувиар, Монгол Улс, 2007, 2011, 2015, 2019 он.....	39
Зураг 4А. 6. Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, боловсролын түвшнээр, Монгол Улс, 2019 он.....	41
Зураг 4А. 7. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хөдөлмөр эхэлдэг эсэхээр, Монгол Улс, 2019 он.....	44
Зураг 4А. 8. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан цаг, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, минутаар, Монгол Улс, 2019 он.....	47
Зураг 4А. 9. Ажлын болон амралтын нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, гэрлэлтийн байдлаар, Монгол Улс, 2019 он.....	50
Зураг 4А. 10. Ажлын болон амралтын нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүүхэдтэй эсэхээр, хамт амьдардаг 16 хүртэлх насны хүүхдийн тоогоор, Монгол Улс, 2019 он.....	53

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
МАА	Мал аж ахуй
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
УБ	Улаанбаатар
ХАА	Хөдөө аж ахуй
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮТС	Үндэсний тооцооны систем
ЦАС	Цаг ашиглалтын судалгаа
ЦАСҮАА	Цаг ашиглалтын статистикт зориулсан үйл ажиллагааны ангилал

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн дагуу Үндэсний Статистикийн хорооноос 4 жил тутамд “Цаг ашиглалтын судалгаа”-г зохион байгуулдаг. Үндэсний Статистикийн хороо өмнөх судалгаануудын мэдээллийг шинэчлэн баяжуулах зорилгоор Цаг ашиглалтын судалгаа (ЦАС)-г 2019 онд зохион байгуулсан.

“Цаг ашиглалтын судалгаа” нь олон улсын нийтлэг аргачлалаар хүн амын амьдралын хэв маягийг тодорхойлох, хөлстэй, хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийг хүйсээр гаргах, нийгэмд байгаа жендэрийн тэгш байдлын бодит байдлыг үнэлж, дүгнэхэд шаардлагатай мэдээллийн эх үүсвэрүүдийн нэг юм.

Манай улсын хувьд хот, хөдөөгийн хүн амын цаг ашиглалтын байдал ихээхэн ялгаатай байдаг бөгөөд тус судалгаанд хүн амын цаг ашиглалтын ерөнхий дүр зураг, түүнд гарсан өөрчлөлтийг амьдарч буй байршил, хүйс, насны бүлэг, боловсролын түвшнээр тооцон гаргасан үр дүнг өмнөх судалгаануудтай харьцуулж болно.

Судалгааны мэдээлэл нь Тогтвортой хөгжлийн зорилгын нэг зорилтын хэрэгжилтийг үнэлж, дүгнэх, гүнзгийрүүлсэн дүн шинжилгээ хийх зэрэгт зохих хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Судалгааны үр дүнгийн тайланд тусгагдсан болон олон нийтэд нээлттэй болгосон анхдагч мэдээлэл нь бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, эрдэмтэн, судлаачид болон статистик тоо мэдээлэл хэрэглэгчдэд үнэ цэнтэй мэдээллийн эх үүсвэр болж чадна.

Ялангуяа энэ удаагийн судалгааны үр дүнг хөдөлмөр эрхлэлтийн байдал, үйлдлийн чадварын хүндрэл, гэрлэлтийн байдал, хүүхэдтэй эсэх үзүүлэлтээр нэмж илүү нарийвчлалтай тооцсон. Эдгээр тоо мэдээлэл нь Засгийн газраас хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, чөлөөт цагаа өнгөрүүлэхэд тулгамдаж буй асуудлыг оновчтой шийдвэрлэх зэргээр хүн амд чиглэсэн үйл ажиллагааны хөтөлбөрт нэн их шаардлагатай үзэж байна.

Судалгааг удирдан зохион байгуулж амжилттай явуулсан Судалгааны үндсэн багийн гишүүд болон өрх, хүн амаас мэдээллийг цуглуулах амаргүй ажлыг гүйцэтгэсэн Мэдээлэл цуглуулах багийн ахлагч, ярилцлага авагч ажилтнууд, судалгаанд хамрагдаж мэдээллээ өгсөн өрхүүдэд талархлаа илэрхийлье.

## ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

## СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

Цаг ашиглалтын судалгааны түүвэрт сонгогдсон 4,000 өрхөөс 3,972 нь судалгаанд бүрэн хамрагдаж, хамрагдалтын түвшин 99.3 хувь байсан. Судалгаанд хамрагдсан өрхөд 12, түүнээс дээш насны нийт 9,820 хүн бүртгэгдсэнээс 6,312 (цаасан асуулга нөхсөн 6,110, гар утасны аппликейшн ашиглаж нөхсөн 202) нь өдрийн тэмдэглэл хөтөлж, хамрагдалтын түвшин 64.3 хувь байлаа.

Монгол Улсын 12, түүнээс дээш насны хүн ам долоо хоногийн нэг өдрийн 308 минутыг хөлстэй хөдөлмөр эрхлэхэд, 214 минутыг хөлсгүй хөдөлмөр эрхлэхэд, үлдсэн 918 минутыг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээндээ зарцуулдаг байна.

Хүн амын цаг ашиглалт ажлын болон амралтын өдрөөр ялгаатай байв. Тодруулбал, ажлын өдөр хөдөлмөр эрхлэх болон боловсрол, сургалтын үйл ажиллагаанд, харин амралтын өдөр гэрийн ажил, чөлөөт цаг, урлаг, спорт болон хувийн хэрэгцээнд илүү цаг зарцуулж байлаа.

Хүн амын цаг ашиглалтын байдлаас гадна амьдралын хэв маяг буюу өдрийн 24 цагийн аль цагт юу хийж байгааг анх удаагаа тооцсон. Үүнээс харахад, 12, түүнээс дээш насны хүн ам 7-22 цагийн хооронд сэрүүн байж, идэвхтэй үйл ажиллагаа хийдэг байна.

Судалгааны үр дүнгээс харахад өглөө 5 хүн тутмын 1 нь 7-8, 2 нь 8-9, 1 нь 9-10 цагийн хооронд сэрдэг байна. Харин орой 21-22 цагийн хооронд 5 хүн тутмын 1 нь, 22-23 цагийн хооронд 5 хүн тутмын 3 нь 23-24 цагийн хооронд 10 хүн тутмын 9 нь унтаж байв.

Хүн амын дийлэнх хэсэг нь өдрийн хоолыг 12-14 цагийн хооронд харин оройн хоолыг 18-21 цагийн хооронд иддэг байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг 20-22 цагийн хооронд хэрэглэж буй хүн ам хамгийн их байлаа.

Хөлсгүй хөдөлмөрийг авч үзэхэд 7-21 цагийн хооронд нийт хүн амын 12-24 хувь нь тогтмол гэрийн ажил хийжээ. Харин өдрийн 8-19 цагийн хооронд хүн амын нэлээдгүй хувь нь хөлстэй хөдөлмөрт цагаа зарцуулж байв. Жишээ нь, энэ хугацаанд 12, түүнээс дээш насны нийт хүн амын 18-29 хувь нь хөдөлмөр эрхэлж байхад 8 хүн тутмын 1 нь өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл хийж байлаа.

### *Хот, хөдөө, хүйс*

Хүн амын цаг ашиглалтын дүр зургийг харахад хүйсээр болон хот, хөдөөгөөр ялгаатай байсаар байна. Өөрөөр хэлбэл, хөдөөгийн хүн ам хөлстэй хөдөлмөр тэр дундаа өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хотын хүн амтай харьцуулахад их цаг зарцуулж байв. Харин хүйсийн ялгаатай байдлыг авч үзэхэд эрэгтэйчүүд хөлстэй хөдөлмөрт, эмэгтэйчүүд хөлсгүй хөдөлмөрт илүү цагийг зарцуулсаар байна.

### *Насны бүлэг*

Насны бүлгээр авч үзвэл цаг ашиглалтын байдалд ялгаа ажиглагдлаа. Тодруулбал, хүүхэд наснаас эхлээд хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагт хүйсийн ялгаатай байдал илэрч байв. Энэ нь магадгүй нийгмийн дунд байдаг охид, эмэгтэйчүүд гэрийн ажил хийх ёстой, гэрийнхнийгээ асрах ёстой гэсэн нийтлэг ойлголттой шууд хамааралтай.

### *Боловсрол*

Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой хүмүүсийн цаг ашиглалтын байдлыг харьцуулахад ялгаа багатай байв. Хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй цаг нь бүрэн дунд болон дээд боловсролтой хүмүүсийн хувьд ижил дунджаар 317 минут байхад техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн амын хувьд хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй цаг нь 330 минут байлаа. Харин хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй дундаж хугацаа нь боловсролын түвшин дээшлэх тусам нэмэгдэж байв.

Энэ удаагийн судалгаанд хүн амын цаг ашиглалтын байдал хөдөлмөр эрхэлдэг эсэхээр, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, гэрлэлтийн байдлаар болон хүүхдийн тооноос хэрхэн хамаарч ялгаатай байгааг харах зорилгоор анх удаагаа нэмэлт хүснэгтүүдийг тооцсон.

### *Хөдөлмөр эрхлэлтийн байдал*

15, түүнээс дээш насны хүн амын цаг ашиглалтын байдлыг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар авч үзэхэд хөдөлмөр эрхэлдэг хүн ам хөлстэй хөдөлмөрт ажлын өдөрт 8.4 цагийг харин хөдөлмөр эрхэлдэггүй хүн ам ажлын эсвэл амралтын өдрөөс үл хамааран өдөрт дунджаар 5.4 цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байв. Энэхүү хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цаг нь хөдөлмөр эрхэлдэг хүн амтай харьцуулахад даруй 2 дахин их байгаа юм. Энэ нь нэг талаас өрхийн хувьд ажил хийдэггүй гэртэй байдаг хүмүүс нь гэрийн ажил болон өрхийн гишүүдийг асрах асуудлыг хариуцдагтай, нөгөө талаас гэрийн ажил зохицуулах эсвэл өрхийн гишүүдийг асрахаар ажлаасаа гарч хөдөлмөр эрхлэхээ болих ч тохиолдол гардагтай холбоотой.

### *Үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэх*

Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын долоо хоногийн 1 өдөрт хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй дундаж хугацаа нь 178 минут байгаа нь үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амтай харьцуулахад даруй 137 минутаар бага байв. Харин хөлсгүй хөдөлмөрт үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн ам илүү цаг зарцуулж байлаа. Гэхдээ цагийн зөрүү нь харьцангуй бага буюу 23 минут байв. Хөлсгүй хөдөлмөрийг задлан авч үзвэл үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүс үйлдлийн чадварын хүндрэлгүй хүмүүстэй харьцуулахад гэрийн ажилд их цаг зарцуулдаг ч өрхийн гишүүдийг асрахад эсрэгээрээ бага цаг зарцуулж байгаа нь магадгүй өөрсдөд нь бусдаас асаргаа, тусламж авах хэрэгцээ илүү байдагтай холбоотой байх талтай юм.

### *Гэрлэлтийн байдал*

Гэрлэлтийн байдлаас хамаарч эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн цаг ашиглалтын байдал бага зэргийн ялгаатай байлаа. Тодруулбал, гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай хүмүүс хөлстэй хөдөлмөрт бусдаасаа илүү цагийг зарцуулж байв. Харин хөлсгүй хөдөлмөрт тусгаарласан, цуцалсан эсвэл бэлэвсэн эрэгтэйчүүд, гэрлэсэн хамтран амьдрагчтай эмэгтэйчүүд илүү цагийг зарцуулдаг байна. Хүүхэдтэй эсэх, хүүхэдтэй бол хамт амьдарч байгаа 16 хүртэлх насны хүүхдийн тоо 18, түүнээс дээш насны хүн амын цаг ашиглалтын байдалд тэр дундаа хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагт ялгаатай дүр зургийг бий болгодог байна. Өөрөөр хэлбэл, 16 хүртэлх насны хамт амьдардаг хүүхдийнх нь тоо нь эрэгтэйчүүдийн хувьд хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй цагтай, харин эмэгтэйчүүдийн хувьд хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагтай шууд хамааралтай байв.

*Тогтвортой хөгжлийн зорилтын үзүүлэлт 5.4.1*

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үүднээс эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийн зөрүүтэй байдлыг багасгах зорилгоор ТХЗ-д хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийг нэг үзүүлэлт болгон оруулсан.

Монгол Улсын хувьд 12, түүнээс дээш насны хүн ам өдөрт дунджаар 205 минутыг хөлсгүй хөдөлмөрт зарцуулдаг байна. Хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүд (4.6 цаг), Улаанбаатар хотынхон (3.7 цаг), 60, түүнээс дээш насныхан (3.9 цаг), дээд боловсролтой (4.0 цаг), хөдөлмөр эрхэлдэггүй (5.1 цаг), үйлдлийн чадварын хүндрэлтэй (3.7 цаг) хүн ам хамгийн их цагийг зарцуулж байв.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТАНИЛЦУУЛГА

Цаг ашиглалтын судалгаа (ЦАС) нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нийгэм, эдийн засаг, өрх гэрт оруулж байгаа хувь нэмрийг тодорхойлоход болон өрхөд үйлдвэрлэгдсэн нэмэгдэл өртгийг үндэсний тооцооны системд оруулахад ашиглагддаг мэдээллийн чухал эх үүсвэрүүдийн нэг юм. Тиймээс ЦАС-г тодорхой давтамжтайгаар тогтмол явуулдаг улс орны тоо жилээс жилд нэмэгдэж байна.

Монгол Улсын хувьд Цаг ашиглалтын туршилтын судалгааг анх 2000 онд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн санхүү, техникийн тусламжтайгаар олон улсын жишиг аргачлалын дагуу явуулсан. “Статистикийн тухай” Монгол Улсын хуульд 2004 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 7.1.к-д “цаг ашиглалтын түүвэр судалгааг 4 жил тутам улирлаар” зохион байгуулж явуулна гэж заасны дагуу 2007 оноос тогтмол зохион байгуулж байна. Ийнхүү Үндэсний статистикийн хороо (ҮСХ) дөрөв дэх удаагийн ЦАС-г 2019 онд амжилттай зохион байгуулж явууллаа.

Уг судалгаа нь Олон улсын түвшинд дэвшүүлсэн Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-ын 5.4.1 үзүүлэлт болох “Гэрийн болон асран халамжлах хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан цаг”-ийг тооцож, ТХЗ-ын хэрэгжилт, явцыг үнэлэх бололцоог олгож байна.

Түүнчлэн ядуурал, ажилгүйдлийг бууруулах, боловсрол, эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэхэд, дэд бүтэц болон нийгмийн үйлчилгээний хангамж, хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалт хийх, жендэрийн тэгш байдлыг хангахад анхаарсан үндэсний түвшний бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллийг бий болгож байгаагаараа онцлог юм.

ЦАС-ны зорилго нь хүн амын эрхэлж байгаа үйл ажиллагааг тодорхойлж, тэдгээрт зарцуулж буй цагийг хэмжих явдал бөгөөд энэ утгаар нь судалгааны зорилтуудыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Хүн амын амьдралын хэв маягийг тодорхойлох, түүнд гарч байгаа өөрчлөлтийг судлах;
- Хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийг хүйсээр гаргах (Тогтвортой хөгжлийн зорилтын 5.4.1);
- Өрхийн түвшинд бий болж буй нэмэгдэл өртгийг тооцох;

Мөн хөлсгүй хөдөлмөрт өрхийн гишүүдийн зарцуулж байгаа цагийг тодорхойлж өрхийн түвшинд бий болж байгаа нэмэгдэл өртгийг тооцох, үндэсний тооцооны систем (ҮТС)-д шаардлагатай тоо мэдээллийг гаргах түүнчлэн бодлого боловсруулахад хэрэгцээтэй тоо мэдээллээр хангадаг.

Судалгааны тайлан нь ерөнхий дүгнэлт, хавсралтыг оролцуулахгүйгээр нийт дөрвөн бүлэгтэй.

Нэгдүгээр бүлэгт, судалгааны танилцуулга, тайлангийн бүтэц, агуулгыг тусгав.



Хоёрдугаар бүлэгт судалгааны түүвэрлэлт, асуулга, мэдээлэл цуглуулалт, мэдээлэл боловсруулалт зэрэг судалгааны арга зүй, зохион байгуулалттай холбоотой мэдээллийг орууллаа.

Гуравдугаар бүлэгт судалгаанд хамрагдсан өрх, өрхийн үзүүлэлтүүд, өдрийн тэмдэглэл хөтөлсөн хүн амын шинж байдлын талаарх мэдээллийг багтаасан.

Дөрөвдүгээр бүлэгт хүн амын цаг ашиглалтын ерөнхий дүр зургийг хүйс, насны бүлэг, байршил, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлтийн байдал, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэх, гэрлэлтийн байдал, хамт амьдардаг хүүхдийн тоогоор хэрхэн ялгаатай байгааг харуулав. Хавсралт А-д хүн амын цаг ашиглалтын байдлыг насны бүлгээр үечлэн хүснэгтээр оруулсан.

Хүн амын цаг ашиглалтын судалгааны тайланг дараах 4 дэд бүлэгтэй боловсрууллаа. Үүнд:

1. Ерөнхий төлөв;
2. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа;
3. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа;
4. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **А. Түүврийн загвар**

Цаг ашиглалтын судалгаа нь өрхөд суурилсан судалгаа тул түүврийн нэгж нь өрх юм. Хүн амын цаг ашиглалтын үзүүлэлтүүдийг үндэсний түвшинд, үүний дотор хот, хөдөө, бүсээр (Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатар) тооцооход хангалттай төлөөлөлтэй байхаар түүврийн хэмжээг тогтоосон.

Улсын хэмжээнд 4,000 өрхийг судалгаанд хамруулж, бүс тус бүрийн хувьд өрхийн тоог квадрат язгуурын аргаар тооцсон. Судалгааны мэдээллийг 4 улирлаар цуглуулдаг тул түүврийн хэмжээг 4 улиралд тэнцүү хуваарилсан.

Өрхүүдийг сонгохдоо олон шатат түүврийн аргыг ашиглав. Эхний шатанд Улаанбаатар хотоос бусад 4 бүсийг төлөөлүүлж тус бүр 2 аймгийг энгийн санамсаргүй аргаар сонгосон. Аймгуудаас сонгогдсон өрхийн тоог Хүснэгт 2.1-д дэлгэрэнгүй харуулав. Хоёр дахь шатанд түүврийн анхан шатны нэгж (ТАШН)-ийг хэмжээнд нь пропорциональ магадлалт түүврийн аргаар тодорхойлсон. Сүүлийн шатанд ТАШН бүрээс судалгаанд хамрагдах 20 өрхийг системчилсэн магадлалт түүврийн аргаар сонголоо. Судалгаанд хамрагдах өрхийн түүврийг улирал тус бүрийн мэдээлэл цуглуулалт явагдах буюу 3, 6, 9, 12 сарын эхний 7 хоногийн байдлаар Хүн ам, өрхийн мэдээллийн санд суурилж хийсэн.

Хүснэгт 2А. 1. Судалгааны түүвэрт сонгогдсон өрхийн тоо, бүс, аймгаар, 2019 он

Аймаг, нийслэл	Судалгаанд сонгогдсон өрхийн тоо	Улиралд сонгогдсон өрхийн тоо
<b>Баруун бүс</b>	<b>720</b>	<b>180</b>
Говь-Алтай	320	80
Ховд	400	100
<b>Хангайн бүс</b>	<b>800</b>	<b>200</b>
Булган	320	80
Хөвсгөл	480	120
<b>Төвийн бүс</b>	<b>720</b>	<b>180</b>
Дундговь	240	60
Төв	480	120
<b>Зүүн бүс</b>	<b>560</b>	<b>140</b>
Дорнод	240	60
Хэнтий	320	80
<b>Улаанбаатар</b>	<b>1,200</b>	<b>300</b>
<b>Улсын дүн</b>	<b>4,000</b>	<b>1,000</b>

## Б. Судалгааны асуулга

Судалгааны асуулгыг судалгааны зорилго, хамрах хүрээ, мэдээллийн хэрэгцээ, шаардлага, өмнөх судалгаатай харьцуулагдах байдлыг харгалзан боловсруулсан.

Энэ удаагийн судалгаанд дараах 3 төрлийн асуулгыг ашигласан.

1. Өрхийн асуулга – өрхийн гишүүдийн хүн ам зүйн мэдээлэл болон сууцны талаарх мэдээллийг цуглуулсан. Дэлгэрэнгүй задалбал өрхийн ам бүлийн бүтэц, өрхийн гишүүдийн боловсрол, эрүүл мэнд, гэр бүлийн байдал, хөдөлмөр эрхлэлт, өрхийн сууцны төрөл, усан хангамж, ариун цэврийн байгууламжийн төрөл, өрхийн хэрэглээний эд зүйлстэй холбоотой мэдээллийг цуглуулав.
2. 5 хүртэлх насны хүүхдийн асуулга – 5 хүртэлх насны хүүхдийн эх, асран хамгаалагчийг хамруулсан. Тухайн өрхөд амьдардаг 5 хүртэлх насны хүүхэд тус бүрийн хувьд сүүлийн 3 сард ханиад, томуугаар өвчилсөн эсэх, өвчилсөн тохиолдолд түүнийг эмчлүүлэх, асрахад гэр бүлийн гишүүд хэчнээн цаг хугацааг зарцуулсан, ажил/ хичээлээсээ чөлөө авсан эсэх, эмчилгээнд хэдэн төгрөг зарцуулсан талаар мэдээлэл цуглуулсан.
3. Өдрийн тэмдэглэл – өрхийн 12, түүнээс дээш насны гишүүдээр хоногийн 24 цагт хийсэн үйл ажиллагаанууд тэдгээрт зарцуулсан хугацааг 10 минутын интервалтайгаар хөтлүүлсэн. Өдрийн тэмдэглэл нь 2 өдөртэй, 3 өдөртэй гэсэн 2 төрөл.

Асуулга боловсруулахад дараах зарчмыг баримталсан. Үүнд:

- Өмнөх судалгаануудтай харьцуулах байдлыг хангах,
- Бусад улс оронтой харьцуулах байдлыг хангах,
- Өөрийн орны онцлог, мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан үзэх.

Судалгааны асуулгыг хавсралт Г-ээс харж болно.

## **В. Судалгаанд ашигласан ангилал**

Энэ удаагийн ЦАС-нд НҮБ-ын Статистикийн Хэлтсээс боловсруулж гаргасан Цаг ашиглалтын статистикт зориулсан үйл ажиллагааны олон улсын ангилал (ЦАСҮАА)-ын 2016 онд шинэчлэгдсэн хувилбарыг мөрдлөг болгон ашигласан. Цаг ашиглалтын статистикийн 2016 онд шинэчлэгдсэн үйл ажиллагааны ангилал нь 9 бүлэг, 52 дэд бүлэг, 165 үйл ажиллагаатай. ЦАСҮАА-ын дэлгэрэнгүйг хавсралт В-ээс харж болно.

Цаг ашиглалтын судалгаанд ЦАСҮАА-аас гадна үндэсний ажил мэргэжлийн ангилал, эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллыг хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдийг тооцоход ашигласан.

## **Г. Мэдээлэл цуглуулах арга**

ЦАС-нд мэдээлэл цуглуулалтын холимог аргыг ашигласан. Тодруулбал, өрхийн мэдээллийг цуглуулахдаа компьютер ашиглан ярилцлага авах (CAPI) аргыг, өдрийн тэмдэглэлийг хөтлүүлэхдээ цаасан асуулга ашиглах болон ухаалаг утасны аппликейшн ашиглах аргуудыг хослуулан хэрэглэсэн. Өдрийн тэмдэглэлийг цаасан маягт ашиглаж хөтөлсөн тохиолдолд ярилцлага авагч нар үйл ажиллагааг кодлоод таблет дээрээ мэдээллийг шивж оруулсан. Харин гар утасны аппликейшн ашиглаж өдрийн тэмдэглэл хөтөлсөн тохиолдолд ҮСХ-ны серверт хувь хүн өөрөө дамжуулсан. Судалгааны мэдээлэл цуглуулалтын CSPro 7.0 (тооллого, түүвэр судалгааны мэдээлэл боловсруулах систем) программыг ашигласан. Ухаалаг утасны аппликейшнийг хөгжүүлэхдээ андройд болон ios үйлдлийн системд зориулан риакт натив (react native) программ хангамжийг ашигласан.

Судалгааны асуулгын дагуу боловсруулагдсан программыг туршиж, туршилтаас гарсан үр дүнд үндэслэн программд шаардлагатай засвар, өөрчлөлт хийж эцэслэн боловсрууллаа.

## **Д. Сургалт**

Судалгааны мэдээлэл цуглуулах ажилтнуудад зориулсан сургалтыг 2 өдөр зохион байгуулсан. Сургалтыг илүү хүртээмжтэй, үр дүнтэй зохион байгуулах зорилгоор бүсчилсэн байдлаар хийсэн. Сургалтыг Баруун бүсэд 2019 оны 3 дугаар сарын 14-15-нд, Зүүн бүсэд 3 дугаар сарын 9-10, Хангайн бүсэд 3 дугаар сарын 10-11-нд, Төвийн бүс болон Улаанбаатар хотыг нэгтгэн 3 дугаар сарын 13-14-нд тус тус зохион байгуулав.

Сургалтад ярилцлага авах арга зүй, асуулгын хуудас тус бүрийн асуултыг зааснаас гадна цаасан асуулгаар, таблет ашиглан ярилцлага авах дадлага хийлгэсэн. Сургалтад судалгаанд сонгогдсон аймгийн статистикийн хэлтсийн дарга нар болон аймаг, дүүргийн статистикийн хэлтсийн судлаач нар нийт 85 хүн хамрагдав.

## **Е. Мэдээлэл цуглуулалт**

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг улирлаар зохион байгуулсан бөгөөд 2019 оны гурав, зургаа, ес, арванхоёрдугаар сарын гурав дахь долоо хоногт зохион байгуулан явууллаа. Судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг сонгогдсон аймгийн Статистикийн хэлтсийн дарга нар ахалж, өрхөд суурилсан судалгааны ярилцлага авагч нар мэдээлэл цуглуулсан.

ЦАС-ны нэг зорилго нь 7 хоногийн өдрүүдэд хүн амын хийж буй ажлын ялгаатай байдлыг харах учраас бид судалгааны мэдээлэл цуглуулалтыг улирал бүр нэг бүтэн долоо хоногийг хамруулж өдрийн тэмдэглэл хөтлүүлсэн. Судалгааны өдрийн тэмдэглэлийг сонгогдсон өрхийн 12, түүнээс дээш насны гишүүд хөтөлсөн. Өдрийн тэмдэглэлийг хөтлүүлэхдээ 7 хоногийн гарагуудыг 3 бүлэгт (1. Ням, Даваа, Мягмар, 2. Лхагва, Пүрэв, 3. Баасан, Бямба) хуваан бүлэг тус бүрт тэнцүү тооны өрх ногдуулж зохион байгуулсан.

Өмнө дурдсанчлан, өдрийн тэмдэглэлийг цаасаар болон гар утасны аппликейшн ашиглаж бөглүүлсэн. Цаасаар өдрийн тэмдэглэл хөтлүүлсэн тохиолдолд ярилцлага авагч хөдөөгийн өрхөд 2 удаа, хот, суурин газарт 3 удаа өрхдөө очиж өдрийн тэмдэглэлийн хөтлөлтийг шалгаж заавар өгч байсан. Харин гар утасны аппликейшн ашиглаж өдрийн тэмдэглэл хөтөлсөн тохиолдолд өрхөд ганц удаа очсон бөгөөд цахим платформ ашиглаж судалгаанд хамрагдагчид заавар, мэдээллийг хүргүүлж байсан.

Ярилцлага авагч нар цаасаар авсан өдрийн тэмдэглэлд бичигдсэн үйл ажиллагааг Цаг ашиглалтын статистикт зориулсан олон улсын ангиллын дагуу кодолж, программд шивж оруулсан. Харин гар утасны аппликейшн ашиглаж хөтөлсөн өдрийн тэмдэглэлийн үйл ажиллагааг цахим платформд ярилцлага авагч нар өөрийн эрхээр орж кодролтыг хийсэн.

## **Ё. Мэдээлэл боловсруулалт**

Улирал бүрийн мэдээлэл цуглуулалтын мэдээллийг баазыг дараа сарын 20-ний дотор ҮСХ-нд дамжуулж байсан бөгөөд ҮСХ-нд мэдээллийн уялдаа холбоог шалгаж, шаардлагатай засваруудыг хийлгэж байв.

ҮСХ-ны судалгааны баг үйл ажиллагааны кодролтыг нэг бүрчлэн шалгаж, эцэслэж үр дүнг тооцоход бэлэн болгосон.

Судалгааны үр дүнгийн үзүүлэлтүүдийг тооцож хүснэгтлэн боловсруулахдаа Нийгмийн шинжлэх ухаанд ашигладаг статистикийн багц программ SPSS 24.0-ийг ашигласан.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ХАМРАЛТ, СУДАЛГААНД ХАМРАГДАГЧДЫН ШИНЖ БАЙДАЛ

### А. Судалгааны хамралт

Цаг ашиглалтын судалгааны түүвэрт сонгогдсон 4,000 өрхөөс 3,972 нь судалгаанд бүрэн хамрагдаж, хамрагдалтын түвшин 99.3 хувь байсан. Хамрагдалтын түвшинг бүсээр авч үзвэл Улаанбаатар хотод хамгийн бага 98.0 хувь, харин Баруун бүсэд хамгийн өндөр буюу бүх өрх нь судалгаанд хамрагдсан байна. Судалгааны хамралтын түвшинг хүснэгт 3.1-д харуулав.

Судалгаанд хамрагдсан өрхөд 12, түүнээс дээш насны нийт 9,820 хүн бүртгэгдсэнээс 6,312 (цаасан асуулга нөхсөн 6,110, гар утасны аппликейшн ашиглаж нөхсөн 202) нь өдрийн тэмдэглэл хөтөлж, хамрагдалтын түвшин 64.3 хувь байлаа. Өдрийн тэмдэглэлийн хөтлөлт Хангайн бүс (59.1 хувь), Зүүн бүс (58.4 хувь), Улаанбаатар хот (56.0 хувь)-д бага байсан.

Өрхийн асуулгад 5 хүртэлх насны 1,489 хүүхэд бичигдсэнээс 1,290 хүүхдийн эх, асран хамгаалагч судалгаанд хамрагдаж, хамрагдалтын түвшин 86.6 хувь байв. Хүүхдийн асуулгын хамрагдалтын түвшин Улаанбаатар хотод хамгийн өндөр 93.0 хувьтай, харин Төвийн бүсэд хамгийн бага 75.9 хувь байна.

Хүснэгт 3А. 1. Судалгаанд хамрагдсан өрхийн тоо, өдрийн тэмдэглэл хөтөлсөн 12, түүнээс дээш насны болон 5 хүртэлх насны хүүхдийн асуулгад хамрагдсан хүн амын тоо, хамрагдалтын түвшин, хот, хөдөө, бүсээр, Монгол Улс, 2019 он

Асуулгын төрөл	Бүгд	Хот, хөдөө		Бүс				
		Хот	Хөдөө	Баруун	Хангай	Төв	Зүүн	УБ
<b>Өрх</b>								
Түүвэрт сонгогдсон	4,000	2,047	1,953	720	800	720	560	1,200
Бүрэн хамрагдсан	3,972	2,019	1,953	720	798	719	559	1,176
Хамрагдалтын түвшин (хувь)	99.3	98.6	100.0	100.0	99.8	99.9	99.8	98.0
<b>Өдрийн тэмдэглэл (12, түүнээс дээш насны хүн ам)</b>								
Хамрагдвал зохих	9,820	5,133	4,687	1,869	1,875	1,581	1,369	3,126
Бүрэн хамрагдсан	6,312	3,134	3,178	1,352	1,109	1,301	799	1,751
Хамрагдалтын түвшин (хувь)	64.3	61.1	67.8	72.3	59.1	82.3	58.4	56.0
<b>5 хүртэлх насны хүүхдийн асуулга</b>								
Хамрагдвал зохих	1,489	823	666	271	221	237	229	531
Бүрэн хамрагдсан	1,290	733	557	225	191	180	200	494
Хамрагдалтын түвшин (хувь)	86.6	89.1	83.6	83.0	86.4	75.9	87.3	93.0

### Б. Судалгаанд хамрагдсан өрхийн үзүүлэлтүүд

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн ерөнхий бүтцийг бүс, байршил, ам бүлийн тоо, өрхийн тэргүүний хүйс, нас, боловсролын түвшин зэрэг үзүүлэлтээр хүснэгт 3Б.1-д харууллаа.

Хүснэгтэд жинлэсэн болон жинлээгүй тоог үзүүлсэн. Уг мэдээлэл нь тайланд тусгагдсан бусад үр дүнг тайлбарлахад чухал ач холбогдолтойн зэрэгцээ судалгааны түүврийн төлөөлөлтэй холбоотой суурь мэдээлэл болдог. Тайлангийн бусад хүснэгтүүдэд зөвхөн жинлэсэн дүнг харуулав. Уг түүврийн жинг нормчилсон тул жинлэсэн болон жинлээгүй

нийт өрхийн тоо тэнцүү байна. Мөн хүснэгтэд судалгаанд хамрагдсан өрхүүдийн мэдээлэлд суурилан тооцсон өрхийн ам бүлийн дундаж тоог (жинлэсэн) харуулсан.

ЦАС-нд хамрагдсан нийт өрхийн 78.1 хувь нь эрэгтэй өрхийн тэргүүнтэй, 21.9 хувь нь эмэгтэй өрхийн тэргүүнтэй байлаа.

Судалгаанд хамрагдсан өрхийг хот, хөдөөгөөр авч үзвэл нийт өрхийн 60.3 хувь нь хот, суурин газар, үлдсэн 39.7 хувь нь хөдөө амьдардаг байна. Үүнийг нарийвчлан задалж байршлаар хүснэгтэд давхар харуулсан.

Өрхийн тэргүүний насны бүлгээр судалгаанд хамрагдсан өрхийг авч үзвэл 66.8 хувь нь 35-64 насны, 20.0 хувь нь 18-34 насны, 12.6 хувь нь 65-84 насны тэргүүнтэй байсан.

Өрхийн тэргүүний боловсролын түвшинг авч үзвэл судалгаанд хамрагдсан нийт өрхийн 26.4 хувь нь бүрэн дунд, 22.0 хувь нь дээд, 20.1 хувь нь техникийн болон мэргэжлийн, 15.8 хувь нь суурь, 11.7 хувь нь бага боловсролтой, үлдсэн 4.0 хувь нь боловсролгүй өрхийн тэргүүнтэй байна.

Ам бүлийн тоогоор судалгаанд хамрагдсан өрхийг авч үзвэл 5 өрх тутмын 3 нь 2-4 ам бүлтэй байгааг хүснэгтээс харж болно. Мөн судалгаанд хамрагдсан өрхийн ам бүлийн дундаж тоо 3.4 байв.

Хүснэгт ЗБ. 1. Судалгаанд хамрагдсан өрхийн эзлэх хувь, сонгосон үзүүлэлтээр, Монгол Улс, 2019 он

Сонгосон үзүүлэлт	Хувь	Өрхийн тоо	
		Жинлэсэн	Жинлээгүй
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>3,972</b>	<b>3,972</b>
<b>Өрхийн тэргүүний хүйс</b>			
Эрэгтэй	78.1	3,103	3,129
Эмэгтэй	21.9	868	841
<b>Бүс</b>			
Баруун	12.1	481	720
Хангай	20.0	793	798
Төв	16.8	668	719
Зүүн	7.3	291	559
Улаанбаатар	43.8	1,738	1,176
<b>Хот, хөдөө</b>			
Хот	60.3	2,396	2,019
Хөдөө	39.7	1,576	1,953
<b>Байршил</b>			
Нийслэл	43.9	1,744	1,183
Аймгийн төв	16.4	652	836
Сумын төв	14.7	582	786
Хөдөөгийн баг	25.0	994	1,167
<b>Өрхийн тэргүүний насны бүлэг</b>			
<18	0.1	2	2
18-34	20.0	794	784
35-64	66.8	2,654	2,670
65-84	12.6	499	492
85+	0.5	22	22
<b>Өрхийн тэргүүний боловсрол</b>			
Боловсролгүй	4.0	159	178
Бага	11.7	465	529
Суурь	15.8	626	706
Бүрэн дунд	26.4	1,046	1,051
Техникийн болон мэргэжлийн	20.1	800	757
Дээд	22.0	875	749
<b>Өрхийн ам бүлийн тоо</b>			
1	13.3	528	550
2	20.5	813	821
3	18.1	717	733
4	22.1	879	848
5	15.3	609	596
6	7.2	287	294
7+	3.5	139	130
<b>Өрхийн ам бүлийн дундаж тоо</b>	<b>3.4</b>	<b>3,972</b>	<b>3,972</b>


Цаг ашиглалтын судалгаанд өрхийн сууц, цахилгаан эрчим хүч болон халаалтын эх үүсвэр, ундны усны эх үүсвэр, ариун цэврийн байгууламжийн төрөл, өрхийн удаан эдэлгээт бараа бүтээгдэхүүн болон тариалангийн талбайн талаарх асуултуудыг асуусан. Эдгээр өрхийн үзүүлэлтийн талаар дэлгэрэнгүйг дор тайлбарлалаа.

Өрхийн амьдарч буй сууц, сууцны халаалт, цахилгаан эрчим хүчний талаарх мэдээллийг зураг ЗБ.1 болон хүснэгт ЗБ.2-т харуулсан.

Нийт өрхийн 44.2 хувь нь гэрт, 34.3 хувь нь сууцны тусдаа байшинд, 19.5 хувь нь орон сууцны байшинд, үлдсэн 2.0 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Өрхийн сууцны төрөл хот, хөдөөгөөр ялгаатай байгааг хүснэгт ЗБ.2-оос харж болно.



Зураг 3Б. 1. Өрхийн амьдарч буй сууцны төрөл, дүнд эзлэх хувиар, Монгол Улс, 2019 он



Цахилгаан, эрчим хүчний эх үүсвэрээр хангагдсан байдлыг харахад улсын хэмжээнд нийт өрхийн 77.2 хувь нь төвлөрсөн системд холбогдсон, 19.8 хувь нь сэргээгдэх эрчим хүч хэрэглэдэг, 2.8 хувь нь дизель станц, бага оврын цахилгаан үүсгүүр ашигладаг, үлдсэн 0.2 хувь нь цахилгаан эрчим хүчээр хангагдаагүй байв. Цахилгаан, эрчим хүчний эх үүсвэр нь хот, хөдөөгөөр ялгаатай байна. Өөрөөр хэлбэл хот суурин газрын бараг бүх өрх (98.2 хувь) төвлөрсөн системд холбогдсон байхад хөдөөгийн өрхийн ердөө тал хүрэхгүй хувь нь (45.3 хувь) төвлөрсөн системд холбогджээ. Бүсээр нь авч үзвэл Улаанбаатар хотын өрхүүд 100.0 хувь төвлөрсөн системд холбогдсон, үүний дараагаар Зүүн (71.8 хувь) болон Баруун (70.5 хувь) бүсийн цахилгаан эрчим хүчний төвлөрсөн системд холбогдсон өрхийн тоо өндөр байна. Бусад бүсийн хувьд нийт өрхийн тал орчим хувь нь төвлөрсөн системд холбогдсон бөгөөд нэлээдгүй өрхүүд сэргээгдэх эрчим хүч хэрэглэдэг гэжээ.

Хүйтний улиралд ашиглаж байгаа халаалтын эх үүсвэрийг тодруулахад улсын хэмжээнд 10 өрх тутмын 7 нь (71.4 хувь) ердийн галлагаа, 2 нь (21.7 хувь) нь төвлөрсөн халаалтын системд холбогджээ. Өмнөх үзүүлэлтүүдтэй адил хот, хөдөөгөөр болон бүсээр халаалтын эх үүсвэр ялгаатай байгаа нь хүснэгтээс харагдаж байна. Тодруулбал, төвлөрсөн халаалтын системд холбогдсон өрхийн хувь Улаанбаатар хотын хувьд 37.9, үүний дараагаар Зүүн бүс 19.6, үлдсэн 3 бүсийн хувьд 4.5-11.9 байв. Үүнтэй уялдаад ердийн галлагаа ашигладаг өрхийн хувь дээрхээс урвуу хамааралтай үр дүнтэй байна.

Нэгтгэн дүгнэвэл Зүүн бүсийн өрхийн сууцны нөхцөл, дэд бүтэц нь Баруун, Хангай болон Төвийн бүстэй харьцуулахад сайн байна.

Хүснэгт ЗБ. 2. Өрхийн сууцны төрөл болон цахилгаан эрчим хүчний болон халаалтын эх үүсвэр, хот, хөдөө болон бүсээр, дүнд эзлэх хувиар, Монгол Улс, 2019 он

Өрхийн сууцны нөхцөл	Бүгд	Хот, хөдөө		Бүс				
		Хот	Хөдөө	Баруун	Хангай	Төв	Зүүн	УБ
<b>Дүн</b>	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
<b>Өрхийн сууцны төрөл</b>								
Орон сууцны байшин	19.5	31.6	1.0	8.7	3.3	5.3	18.0	35.5
Бие даасан тохилог сууц	0.3	0.5	0.0	0.3	0.2	0.6	0.9	0.3
Сууцны тусдаа байшин	34.3	36.7	30.8	21.7	46.7	25.3	36.4	35.4
Нийтийн байр	1.4	1.7	1.0	0.3	1.4	0.7	2.2	1.8
Гэр	44.2	29.3	66.9	68.8	48.1	68.1	41.6	26.9
Бусад	0.2	0.2	0.2	0.1	0.3	0.0	0.9	0.2
<b>Цахилгаан эрчим хүчний эх үүсвэр</b>								
Төвлөрсөн систем	77.2	98.2	45.3	70.5	51.8	55.3	71.8	100.0
Дизель станц	0.0	0.0	0.1	0.0	0.1	0.1	0.0	0.0
Сэргээгдэх эрчим хүч	19.8	1.7	47.4	21.9	46.1	35.1	27.8	0.0
Бага оврын цахилгаан үүсгүүр	2.8	0.0	6.9	7.4	2.0	8.7	0.2	0.0
Цахилгаан эрчим хүчгүй	0.2	0.1	0.3	0.1	0.0	0.7	0.2	0.0
<b>Халаалтын эх үүсвэр</b>								
Төвлөрсөн системд	21.7	34.7	1.9	11.9	4.5	7.9	19.6	37.9
Цахилгаан халаагуур	2.0	3.2	0.2	0.3	0.1	0.2	0.7	4.3
Нам даралтын зуух	4.8	6.4	2.4	5.0	1.9	4.2	2.2	6.7
Ердийн галлагаа	71.4	55.5	95.5	82.8	93.5	87.7	77.3	50.8
Бусад	0.1	0.2	0.0	0.0	0.0	0.0	0.2	0.3
<b>Өрхийн тоо</b>	3,972	2,396	1,576	481	793	668	291	1,738

Өрхийн сууц болон эд хөрөнгийн өмчлөлийн үзүүлэлтийг хүснэгт ЗБ.3-д харууллаа. Судалгаанд асуусан удаан эдэлгээт бараа бүтээгдэхүүн болон тариалангийн талбай эзэмшдэг өрхийн хувь хот, хөдөөгөөр ялгаатай байна. Ихэнх удаан эдэлгээт цахилгаан бараа болох компьютер, угаалгын машин, хөргөгч, хөлдөөгч, тоос сорогч зэрэг нь хотын өрхүүдэд илүү байна. Харин тээврийн хэрэгслийн хувьд суудлын машинтай өрхийн хувь хотод их байхад ачааны машин, мотоциклтай өрхийн хувь хөдөөд их байна.

Монгол Улсын нийт өрхийн 92.1 хувь нь өөрийн сууцанд, 4.1 хувь нь түрээсгүйгээр бусдын сууцанд, 2.8 хувь нь түрээсийн байранд, үлдсэн 1.0 хувь нь бусад сууцанд амьдардаг байна.

Хүснэгт ЗБ. 3. Өрхийн эзэмшдэг эд зүйлс болон сууцны өмчлөл, хот, хөдөө, болон бүсээр, дүнд эзлэх хувиар, Монгол Улс 2019 он

Үзүүлэлт	Бүгд	Хот, хөдөө		Бүс				
		Хот	Хөдөө	Баруун	Хангай	Төв	Зүүн	УБ
<b>Өрхийн эд зүйлс</b>								
Нарны таваг	26.0	4.3	59.0	42.4	49.4	45.0	31.5	2.6
Зурагт	95.8	97.0	94.0	93.9	95.8	92.9	96.3	97.4
Компьютер	25.5	35.0	11.0	17.3	14.0	14.8	16.3	38.6
Угаалгын машин	72.7	88.9	48.1	61.1	54.1	60.8	63.2	90.6
Хөргөгч/ хөлдөөгч	81.6	95.9	60.0	72.0	62.0	71.5	78.8	97.6
Тоос сорогч	34.3	45.4	17.4	27.9	22.0	25.5	20.7	47.4
Богино долгионы зуух	24.8	33.4	11.7	7.9	14.0	24.1	18.4	35.7
Суудлын машин	42.3	48.9	32.2	37.2	32.8	38.7	33.3	50.9
Дунд болон том оврын жийп	4.4	4.0	5.0	7.3	3.9	4.8	5.4	3.5
Автобус/ микро автобус	1.3	1.1	1.6	3.9	1.8	1.2	1.2	0.5
Ачааны машин	13.5	4.4	27.4	16.4	21.0	27.2	19.5	3.1
Мотоцикл	24.2	3.7	55.4	42.5	46.0	45.9	25.0	0.8
Тариалангийн талбай	5.2	3.9	7.1	4.8	5.4	7.7	9.3	3.5
<b>Сууцны өмчлөл</b>								
Өөрийн сууц	92.1	90.3	94.7	95.0	93.8	94.6	92.8	89.4
Өөрийн сууц биш - Түрээстэй	2.8	4.3	0.6	0.9	0.4	1.4	1.5	5.3
Өөрийн сууц биш - Түрээсгүй	4.1	4.7	3.2	2.4	4.6	2.6	5.6	4.7
Бусад	1.0	0.7	1.5	1.7	1.2	1.4	0.2	0.7
<b>Өрхийн тоо</b>	3,972	2,396	1,576	481	793	668	291	1,738

Өрхийн ундны ус болон ариун цэврийн байгууламжийн талаарх мэдээллийг хүснэгт ЗБ.4, ЗБ.5-д үзүүлсэн.

Хүснэгт ЗБ.4-өөс харахад Монгол Улсын нийт өрхийн 21.1 хувь нь цэвэр усны төвлөрсөн систем, мөн адил 21.1 хувь нь хамгаалагдсан гүний худаг, 15.9 хувь нь төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр, 13.6 хувь нь төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр, 11.6 хувь нь ундны усны сайжруулсан бусад эх үүсвэрээс, үлдсэн 16.7 хувь нь ундны усны сайжруулаагүй эх үүсвэрүүдээс ундны усаа авдаг байна. Хот, хөдөөгөөр болон бүсээр ялгаатай дүр зурагтай байгааг хүснэгтээс харж болно.

Нийт өрхийн 24.7 хувийнх нь ундны усны эх үүсвэр нь сууц эсвэл хашаанд нь байдаг гэжээ. Ундны усны эх үүсвэр нь сууц эсвэл хашаанд нь байдаггүй бөгөөд усаа авахдаа 30 хүртэлх минут зарцуулдаг өрх нийт өрхийн 56.9 хувийг, 30, түүнээс дээш минут зарцуулдаг өрх 18.1 хувийг эзэлдэг байна.

Хүснэгт ЗБ. 4. Өрхийн ундны усны эх үүсвэр, ундны ус авахад зарцуулдаг хугацаа, хот, хөдөө болон бүсээр, дүнд эзлэх хувиар, Монгол Улс 2019 он

Ундны усны үзүүлэлт	Бүгд	Хот, хөдөө		Бүс				
		Хот	Хөдөө	Баруун	Хангай	Төв	Зүүн	УБ
<b>Дүн</b>	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
<b>Ундны усны эх үүсвэр</b>								
<b>Сайжруулсан</b>								
Төвлөрсөн системд холбогдсон	21.1	34.1	1.4	10.2	4.4	7.0	19.0	37.6
Төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр	13.6	22.6	0.0	1.4	0.6	11.5	12.4	23.9
Төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр	15.9	21.4	7.6	1.3	15.3	6.8	9.1	25.0
Хамгаалагдсан гүний худаг	21.1	14.4	31.4	35.2	27.8	29.4	28.3	9.8
Хамгаалагдсан гар худаг	4.6	0.5	10.7	8.8	2.1	14.1	8.8	0.2
Хамгаалагдсан булаг, шанд	1.9	0.1	4.7	1.4	7.3	1.1	1.4	0.1
Зөөврийн усны үйлчилгээ	4.1	2.8	6.0	5.5	5.2	7.7	4.7	1.7
Цэвэршүүлж савласан ус	0.9	1.2	0.4	6.1	0.2	0.0	1.5	0.0
<b>Сайжруулаагүй</b>								
Хамгаалагдаагүй гүний худаг	1.3	0.5	2.6	2.5	1.9	2.9	2.2	0.0
Хамгаалагдаагүй гар худаг	4.1	1.0	8.8	6.1	0.8	18.4	1.0	0.0
Хамгаалагдаагүй булаг, шанд	2.2	0.1	5.3	7.3	4.6	0.5	2.9	0.2
Ердийн хөсгөөрх зөөврийн ус	0.7	1.1	0.1	0.2	0.1	0.1	0.2	1.6
Хурын ус	0.3	0.0	0.8	2.0	0.2	0.0	0.4	0.0
Гадаргын ус	8.1	0.1	20.2	12.1	29.7	0.5	8.1	0.0
<b>Ус авахад зарцуулдаг хугацаа</b>								
Ундны усны эх үүсвэр сууц/ хашаанд нь байдаг	24.7	37.1	5.7	26.1	6.5	9.0	24.2	38.6
Ундны усны эх үүсвэр нь сууц/ хашаанд нь байдаггүй								
30 хүртэлх минут	56.9	51.2	65.4	56.2	65.0	72.3	46.6	49.1
30, түүнээс дээш минут	18.1	11.4	28.4	17.4	27.9	18.3	29.1	12.0
Мэдэхгүй/ хариулаагүй	0.3	0.3	0.5	0.3	0.6	0.3	0.0	0.3
<b>Өрхийн тоо</b>	3,972	2,396	1,576	481	793	668	291	1,738

Өрхийн ашигладаг ариун цэврийн байгууламж болон ариун цэврийн байгууламжаа бусадтай хамтран ашигладаг эсэхийг хүснэгт ЗБ.5-д харуулав. Нийт өрхийн 66.1 хувь нь энгийн нүхэн жорлон, 20.2 хувь нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон ариун цэврийн байгууламж, 10.3 хувь нь хээрийн нөхцөл буюу ямар нэгэн ариун цэврийн байгууламжгүй, 1.8 хувь нь сайжруулсан нүхэн жорлон, үлдсэн 1.6 хувь нь бусад төрлийн ариун цэврийн байгууламж ашигладаг байна. Үүнээс гадна ариун цэврийн байгууламжаа бусадтай хамтран ашигладаг эсэхийг тодруулахад нийт өрхийн 78.6 хувь нь дангаараа ашигладаг, үлдсэн 21.4 хувь нь бусадтай хамтран ашигладаг гэж хариулжээ. Ариун цэврийн байгууламжийн төрөл болон хамтран ашигладаг эсэх нь хот, хөдөө, бүсээр ялгаатай байгааг хүснэгтээс дэлгэрэнгүй харж болно.

Хүснэгт ЗВ. 5. Өрхийн ариун цэврийн байгууламжийн төрөл болон ариун цэврийн байгууламжаа бусадтай хамтран хэрэглэдэг эсэх, хот, хөдөө болон бүсээр, дүнд эзлэх хувиар, Монгол Улс 2019 он

Ариун цэврийн байгууламжийн үзүүлэлт	Бүгд	Хот, хөдөө		Бүс				
		Хот	Хөдөө	Баруун	Хангай	Төв	Зүүн	УБ
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Ариун цэврийн байгууламжийн төрөл</b>								
Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон	20.2	33.5	0.1	9.7	3.8	6.1	14.3	37.1
Битүү тунгаагуур	0.3	0.0	0.7	0.1	0.0	0.3	3.1	0.0
Соруулдаг бохир усны цооног	1.1	1.3	0.7	0.2	0.3	0.7	2.1	1.6
Сайжруулсан нүхэн жорлон	1.8	2.1	1.4	2.2	6.3	0.7	0.4	0.4
Энгийн нүхэн жорлон	66.1	62.0	72.3	61.2	81.0	61.7	75.6	60.7
Био жорлон	0.2	0.2	0.1	0.0	0.3	0.0	0.0	0.2
Хээрийн нөхцөл/ ил задгай	10.3	0.8	24.7	26.6	8.3	30.4	4.5	0.0
<b>Ариун цэврийн байгууламжаа бусадтай хамтарч хэрэглэдэг эсэх</b>								
Бусадтай хамт ашигладаг	21.4	22.7	18.9	40.2	13.4	21.6	18.0	21.5
Дангаараа ашигладаг	78.6	77.3	81.1	59.8	86.6	78.4	82.0	78.5
<b>Өрхийн тоо</b>	<b>3,972</b>	<b>2,396</b>	<b>1,576</b>	<b>481</b>	<b>793</b>	<b>668</b>	<b>291</b>	<b>1,738</b>

## В. Судалгаанд хамрагдсан хүн амын үзүүлэлтүүд

Судалгаанд хамрагдсан өрхийн хүн амын нас, хүйсийн тархалтыг хүснэгт ЗВ.1-д үзүүлэв. Цаг ашиглалтын судалгаанд хамрагдсан 3,972 өрхөд нийт 13,627 хүн амьдарч байв. Үүнээс 49.2 хувь нь эрэгтэй, 50.8 хувь нь эмэгтэй байлаа. Нийт хүн амын 36.2 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд байсан бол 63.8 хувь нь 18, түүнээс дээш насны насанд хүрэгчид байна.

Хүснэгт ЗВ. 1. Өрхөд амьдардаг хүн амын эзлэх хувь, 5 насны бүлэг, хүүхэд (0-11 насны), өсвөр насныхан (12-17 насны) болон насанд хүрсэн (18, түүнээс дээш насны) хүн амын эзлэх хувь, хүйсээр, Монгол Улс, 2019 он

Насны бүлэг	Эрэгтэй		Эрэгтэй		Бүгд	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>Бүгд</b>	<b>6,702</b>	<b>100.0</b>	<b>6,925</b>	<b>100.0</b>	<b>13,627</b>	<b>100.0</b>
<b>Насны бүлэг</b>						
0-4	804	12.0	723	10.4	1,526	11.2
5-9	803	12.0	780	11.3	1,583	11.6
10-14	652	9.7	609	8.8	1,261	9.3
15-19	494	7.4	435	6.3	929	6.8
20-24	408	6.1	396	5.7	804	5.9
25-29	439	6.6	439	6.3	879	6.4
30-34	499	7.4	554	8.0	1,053	7.7
35-39	529	7.9	529	7.6	1,059	7.8
40-44	506	7.5	521	7.5	1,027	7.5
45-49	416	6.2	440	6.4	856	6.3
50-54	351	5.2	391	5.7	743	5.5
55-59	288	4.3	352	5.1	640	4.7
60-64	220	3.3	288	4.2	508	3.7
65-69	129	1.9	182	2.6	312	2.3
70-74	81	1.2	106	1.5	187	1.4
75-79	47	0.7	101	1.5	147	1.1
80-84	27	0.4	46	0.7	74	0.5
85+	9	0.1	30	0.4	39	0.3
<b>Хүүхэд, насанд хүрсэн хүн ам</b>						
Хүүхэд (0-11 нас)	1,920	28.6	1,815	26.2	3,735	27.4
Өсвөр насныхан (12-17 нас)	638	9.5	563	8.1	1,200	8.8
Насанд хүрэгчид (18+ нас)	4,145	61.8	4,547	65.7	8,692	63.8

Өдрийн тэмдэглэл хөтөлсөн 12, түүнээс дээш насны хүн амын 58.9 хувь нь эмэгтэй, 41.1 хувь нь эрэгтэйчүүд байна. Харин хот, хөдөө, бүсээр авч үзвэл хотынхон 62.8 хувь, Улаанбаатар хотынхон 46.7 хувийг эзэлж байлаа. Насны бүлгийн хувьд авч үзвэл 30-69 насныхан нийт өдрийн тэмдэглэл хөтөлсөн хүн амын 61.5 хувийг эзэлж байна. Мөн 5.7 хувь нь үйлдлийн чадварын хүндрэлтэй, 33.6 хувь нь хөдөлмөр эрхэлдэг хүн ам байв.

Хүснэгт 3В. 2. Өдрийн тэмдэглэл хөтөлсөн 12, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь, сонгосон үзүүлэлтээр, Монгол Улс, 2019 он

Сонгосон үзүүлэлт	Жинлэсэн хувь	Хүн амын тоо	
		Жинлэсэн	Жинлээгүй
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>6,312</b>	<b>6,312</b>
<b>Бүс</b>			
Баруун	12.7	802	1,352
Хангай	18.6	1,175	1,109
Төв	14.7	929	1,301
Зүүн	7.3	458	799
Улаанбаатар	46.7	2,948	1,751
<b>Хот, хөдөө</b>			
Хот	62.8	3,966	3,134
Хөдөө	37.2	2,346	3,178
<b>Байршил</b>			
Нийслэл	46.9	2,958	1,765
Аймгийн төв	16.0	1,007	1,369
Сумын төв	14.0	885	1,296
Хөдөө	23.1	1,461	1,882
<b>Хүйс</b>			
Эрэгтэй	41.1	2,596	2,718
Эмэгтэй	58.9	3,716	3,594
<b>Насны бүлэг</b>			
12-17	8.9	559	549
18-24	6.7	421	401
25-29	8.4	529	511
30-39	23.7	1,494	1,493
40-49	21.5	1,355	1,393
50-59	16.3	1,028	1,060
60-69	9.9	627	628
70+	4.7	299	277
<b>Боловсрол</b>			
Боловсролгүй	2.7	172	211
Бага	11.9	751	870
Суурь	17.1	1,080	1,203
Бүрэн дунд	25.8	1,628	1,622
Техникийн болон мэргэжлийн	16.9	1,067	1,018
Дээд	25.6	1,614	1,388
<b>Гэрлэлтийн байдал</b>			
Огт гэрлээгүй	16.0	961	923
Гэрлэсэн/ хамтран амьдрагчтай	69.5	4,185	4,283
Тусгаарласан/ салсан/ бэлэвсэн	14.5	873	803
<b>Үйлдлийн чадвар</b>			
Хүндрэлтэй	94.3	5,953	5,953
Хүндрэлгүй	5.7	359	359
<b>Хөдөлмөр эрхэлдэг эсэх</b>			
Хөдөлмөр эрхэлдэг	33.6	2,119	1,960
Хөдөлмөр эрхэлдэггүй	61.8	3,901	4,049
Хариулаагүй	4.6	293	303

Өдрийн тэмдэглэл хөтөлсөн гараг болон өдрийн тоог байршил насны бүлэг, хүйсээр Хүснэгт 3В.3, 3В.4-т харууллаа. Өдрийн тэмдэглэлийг хөтлөхдөө 1) лхагва, пүрэв 2) баасан, бямба 3) ням, даваа, мягмар гэсэн 3 хувилбараар хувааж хөтлүүлсэн тухай өмнө

дурдсан. Тэгвэл 7 хоногийн бүх гарагуудыг жигд хамруулах зорилгоор дээрх гурван хувилбарыг гуравны нэгээр нь хуваарилж тэмдэглэл хөтлүүлсэн юм. Тэгвэл нийт өдрийн тэмдэглэл хөтөлсөн хүн амын хувь харьцангуй жигд бус бага зэргийн өөрчлөлттэй байна.

Улсын дүнгээр авч үзвэл тэмдэглэл хөтөлсөн 12, түүнээс дээш насны хүн амын 35.8 хувь нь лхагва, пүрэв гарагт тэмдэглэл хөтөлсөн бол 30.3 хувь нь баасан, бямба гарагт, үлдсэн 33.9 хувь нь ням, даваа, мягмар гарагт тэмдэглэл хөтөлжээ. Сумын төвийн хүн амын баасан, бямба гарагт (28.1 хувь) тэмдэглэл хөтөлсөн байдал бусад байршилтай харьцуулахад бага байна.

Өдрийн тэмдэглэлийг 2 болон 3 өдрөөр тэмдэглүүлсэн боловч зарим тохиолдолд судалгаанд хамрагдагчийн хувийн шалтгаанаас шалтгаалж зарим өдрийг нөхөхгүй үлдээх тохиолдлууд байлаа. Энэ тохиолдолд бүрэн нөхөгдсөн өдрийн мэдээллийг тооцоонд ашигласан.

Улсын дунджаар судалгаанд өдрийн тэмдэглэл хөтөлсөн хүн амын 66.3 хувь нь 2 өдөртэй тэмдэглэл хөтөлсөн бол 32.7 хувь нь 3 өдөртэй, 1.0 хувь нь 1 өдөр тэмдэглэл хөтөлжээ. Хөдөөд (69.6 хувь) 2 өдөр тэмдэглэл хөтөлсөн хувь бусад байршилтай харьцуулахад илүү байлаа.

Хүснэгт 3В. 3. Өдрийн тэмдэглэл хөтөлсөн 12, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь, байршил, хүйс, гараг, тэмдэглэл хөтөлсөн өдрийн тоогоор, Монгол Улс, 2019 он

Үзүүлэлт	Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	Улсын дундаж
<b>Өдрийн тэмдэглэл хөтөлсөн гараг</b>					
Лхагва, пүрэв	36.4	34.8	33.7	36.7	35.8
Баасан, бямба	29.3	30.6	28.1	33.3	30.3
Ням, даваа, мягмар	34.3	34.6	38.2	30.0	33.9
<b>Өдрийн тэмдэглэл хөтөлсөн өдрийн тоо</b>					
1	0.5	1.1	0.9	2.0	1.0
2	65.8	65.7	63.6	69.6	66.3
3	33.8	33.2	35.5	28.4	32.7
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Өдрийн тэмдэглэл хөтөлсөн 12, түүнээс дээш насны хүн амын тоо	2,958	1,007	885	1,461	6,312

Хүснэгт 3В.4-өөс харахад 60, түүнээс дээш насныхны хувьд 3 өдөртэй буюу ням, даваа, мягмар гарагт тэмдэглэл хөтөлсөн хувь (38.5 хувь) өндөр гарчээ. Харин 18-24 насны залуучууд (69.3 хувь) 2 өдөр тэмдэглэл хөтөлсөн хувь бусад насны бүлгээс илүү байна. Энэ нь эдгээр хүмүүс 3 өдөртэй тэмдэглэл хөтлөхөөс татгалзах, дутуу хөтөлсөнтэй холбоотой байж болох юм.

Хүснэгт 3В. 4.Өдрийн тэмдэглэл хөтөлсөн 12, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь, насны бүлэг, хүйс, гараг, тэмдэглэл хөтөлсөн өдрийн тоогоор, Монгол Улс, 2019 он

Үзүүлэлт	12-17	18-24	25-39	40-59	60+
<b>Өдрийн тэмдэглэл хөтөлсөн гараг</b>					
Лхагва, пүрэв	36.4	39.5	35.1	37.3	31.7
Баасан, бямба	27.7	28.4	32.1	29.8	29.8
Ням, даваа, мягмар	35.9	32.1	32.8	32.9	38.5
<b>Өдрийн тэмдэглэл хөтөлсөн өдрийн тоо</b>					
1	0.9	0.3	1.5	0.7	1.0
2	64.5	68.0	66.8	67.8	61.8
3	34.5	31.7	31.7	31.4	37.2
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Өдрийн тэмдэглэл хөтөлсөн 12, түүнээс дээш насны хүн амын тоо	559	421	2,023	2,383	926

Энэ удаагийн судалгаанд 12, түүнээс дээш насны хүн амын үйлдлийн чадварыг тодорхойлох бүлэг асуултыг оруулсан. Энэхүү асуулга нь НҮБ-ын Статистикийн Комиссын дэргэд байгуулагдсан НҮБ-ын хотын бүлэг буюу “Хөгжлийн бэрхшээлийн статистикийн Вашингтон бүлэг”-ээс боловсруулсан "богино хэмжээний багц" асуултуудад суурилсан. Эдгээр асуулт нь хөгжлийн бэрхшээлийг хэмжих зургаан ай буюу харах, сонсох, явах, танин мэдэх, өөртөө халамж анхаарал тавих, харилцан ойлголцох зэргийг хамарсан.

Тэмдэглэл хөтөлсөн 12, түүнээс дээш насны хүн амын 5.7 хувь нь аль нэг үйлдлийн чадварын хувьд хүндрэлтэй байна.

Хүндрэлийн төрлөөр харвал, алхахад хүндрэлтэй гэж хариулсан хувь хамгийн их буюу 2.9 хувь, харахад хүндрэлтэй гэж хариулсан хувь 1.9 хувь, бусад үйлдлийн чадварын хүндрэлийн хувь 0.1-1.0 байна. Харах, сонсох бэрхшээлийг тодруулахдаа харааны шил, контакт линз зүүдэг, сонсголын аппарат зүүдэг хүний хувьд эдгээр зүйлсээ хэрэглэсэн хэдий ч харах эсвэл сонсоход хүндрэлтэй байдаг уу гэх байдлаар тодруулсан.

Харааны шил эсвэл контакт линз зүүдэг 12, түүнээс дээш насны хүн амын хувь 18.7, сонсголын аппарат зүүдэг хувь 5.8 байна. Хотынхны хувьд харааны шил эсвэл контакт линз зүүх нь хөдөөгийнхтэй харьцуулахад өндөр гарчээ (Хүснэгт 3В.5).



Хүснэгт 3В. 5. Өдрийн тэмдэглэл хөтөлсөн 12, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэх, үйлдлийн чадварын хүндрэлийн төрлөөр, хот, хөдөө, хүйсээр, Монгол Улс, 2019 он

Үзүүлэлт	Хот, хөдөө		Хүйс		Улсын дундаж
	Хот	Хөдөө	Эрэгтэй	Эмэгтэй	
<b>Харааны шил/ контакт линз, сонсголын аппарат зүүдэг эсэх</b>					
Харааны шил эсвэл контакт линз зүүдэг	21.7	13.7	14.9	21.4	18.7
Сонсголын аппарат зүүдэг	6.4	4.8	5.7	5.8	5.8
<b>Үйлдлийн чадварын хүндрэлийн төрөл</b>					
Харах	1.7	2.3	1.6	2.2	1.9
Сонсох	0.7	1.6	1.2	0.9	1.0
Алхах	2.5	3.6	3.2	2.7	2.9
Өөртөө анхаарал тавих	0.4	0.6	0.6	0.4	0.5
Харилцах	0.1	0.1	0.1	0.1	0.1
Ой тогтоолт/ санах	0.7	1.0	0.7	0.9	0.8
<b>Наад зах нь нэг үйлдлийн чадварын хүндрэлтэй 12, түүнээс дээш насны хүн амын хувь</b>					
12, түүнээс дээш насны хүн амын тоо	3,966	2,346	2,596	3,716	6,312

Хүснэгт 3В.6-д хөдөлмөр эрхэлдэг 15, түүнээс дээш насны хүн амын хувийг хөдөлмөр эрхлэлтийн байдал, эрхэлдэг ажил мэргэжлийн ангилал, сүүлийн 7 хоногт үндсэн ажилдаа зарцуулсан дундаж хугацааг хот, хөдөө, хүйсээр харуулав.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал болон ажил мэргэжил хот, хөдөө болон хүйсээр ялгаатай байна. Тодруулбал, хөдөөгийн хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэйчүүдийн 63.4 хувь, эмэгтэйчүүдийн 47.2 хувь нь зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйд хувь нэмрээ оруулагч гэсэн статустай байгаа нь мал аж ахуй эрхэлдэгтэй шууд холбоотой. Харин хот суурин газрын хөдөлмөр эрхэлж байгаа хүн амын хувьд ихэнх нь (эрэгтэй 64.8 хувь, эмэгтэй 74.5 хувь) цалин хөлстэй байнгын ажиллагч байна.

Хотын хөдөлмөр эрхлэгч эрэгтэйчүүдийн 19.9 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил, 18.1 хувь нь худалдаа үйлчилгээний ажилтан, 17.0 хувь нь машин механизм, төхөөргийн операторч, угсрагч, 14.4 хувь нь мэргэжилтэн, 10.1 хувь нь менежерийн ажил эрхэлж байна. Харин хотын хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүдийн хувьд дийлэнх нь худалдаа үйлчилгээний ажилтан (28.8 хувь), мэргэжилтэн (26.9 хувь), энгийн ажил (12.6 хувь) эрхэлж байна.

Хөдөөгийн хувьд хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дийлэнх нь (харгалзан 75.7 болон 65.5 хувь) хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан гэсэн ангилалд багтаж байна.

Улсын хэмжээнд хөдөлмөр эрхэлдэг эрэгтэйчүүд судалгааны өмнөх 7 хоногт дунджаар 55 цаг, эмэгтэйчүүд 47 цаг ажилдаа зарцуулсан гэж хариулжээ. Уг үзүүлэлтийг хот, хөдөөгөөр авч үзэхэд хөдөөд өндөр байна. Тухайлбал, судалгаанаас өмнөх 7 хоногт хөдөөгийн эрэгтэйчүүд (эмэгтэйчүүд) ажилдаа дунджаар 61 цаг (50) цаг зарцуулсан нь хотын эрэгтэйчүүдтэй харьцуулахад 12 (4) цагаар илүү байв. Энэ нь хөдөөгийн хүн амын хувьд дийлэнх нь мал аж ахуй эрхэлдэгтэй холбоотой юм.

Хүснэгт 3В. 6. Өдрийн гэмдэглэл хөтөлсөн 15, түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлдэг хүн амын эзлэх хувь, хөдөлмөр эрхлэлтийн байдал болон ажил мэргэжлийн ангиллаар, мөн сүүлийн 7 хоногт үндсэн ажилдаа зарцуулсан дундаж хугацаа, хот, хөдөө, хүйсээр, Монгол Улс, 2019 он

Үзүүлэлт	Хот		Хөдөө		Улсын дундаж	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Хөдөлмөр эрхлэлтийн байдал</b>						
Цалин хөлстэй ажиллагч						
Байнгын ажиллагч	64.8	74.5	19.0	27.2	42.9	53.9
Түр ажиллагч	6.8	4.5	2.8	1.5	4.9	3.2
Тохиолдлын ажиллагч	0.9	0.8	0.4	0.3	0.7	0.5
Дагалдан, мэргэшиж буй дадлагажигч	0.1	0.3	0.0	0.2	0.0	0.2
Гүйцэтгэх гэрээлэгч	0.7	0.9	0.8	0.3	0.7	0.6
Ажил олгогч:						
ААНБ-ын	2.4	1.0	0.4	0.3	1.4	0.7
Зах зээлд чиглэсэн өрхийн ААН-ийн	2.4	1.1	6.0	3.7	4.1	2.2
Ажилтан ажиллуулдаггүй:						
ААНБ-ын үйл ажиллагаа эрхлэгч	2.3	1.7	1.0	1.0	1.7	1.4
Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуй эрхлэгч	17.0	9.4	63.4	18.5	39.2	13.3
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	2.8	5.9	6.3	47.2	4.5	23.8
<b>Ажил мэргэжлийн ангилал</b>						
Зэвсэгт хүчин	1.5	0.2	0.7	0.0	1.1	0.1
Менежер	10.1	5.9	2.8	2.9	6.6	4.6
Мэргэжилтэн	14.4	26.9	4.1	11.7	9.5	20.3
Техникийн болон туслах/ дэд мэргэжилтэн	2.6	3.9	0.8	1.7	1.7	2.9
Контор үйлчилгээний ажилтан	2.4	8.5	0.7	1.4	1.5	5.4
Худалдаа үйлчилгээний ажилтан	18.1	28.8	3.4	9.9	11.0	20.6
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	4.6	3.1	75.7	65.5	38.6	30.2
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил	19.9	9.1	3.9	1.8	12.2	5.9
Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч	17.0	1.0	4.9	0.4	11.2	0.7
Энгийн ажил, мэргэжил	9.4	12.6	3.1	4.5	6.4	9.1
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Сүүлийн 7 хоногт үндсэн ажилдаа зарцуулсан дундаж цаг</b>	<b>49</b>	<b>46</b>	<b>61</b>	<b>50</b>	<b>55</b>	<b>47</b>
15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхэлдэг хүн амын тоо	961	1,166	880	894	1,841	2,060

Хөдөлмөр эрхэлж буй хүн амын ажиллаж буй эдийн засгийн салбар хот, хөдөө, хүйсээр мөн л харилцан адилгүй байв (Хүснэгт 3В.7).

Хотын хөдөлмөр эрхлэгч эрэгтэйчүүдийн 66.5 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар, үйлчилгээ (16.5 хувь), барилга (14.8 хувь), төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал (13.4 хувь), тээвэр, агуулахын үйл ажиллагаа (12.1 хувь), боловсруулах үйлдвэрлэл (9.7 хувь)-ийн салбарт хөдөлмөр эрхэлж байна.

Харин хотын хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн 67.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар, үйлчилгээ (19.6 хувь), боловсрол (15.8 хувь), төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал (12.3 хувь), боловсруулах үйлдвэрлэл (11.2 хувь), зочид буудал, байр, сууц, болон нийтийн хоолны үйлчилгээ (8.2 хувь)-ийн салбарт ажиллаж байна.

Тэгвэл хөдөөгийн хөдөлмөр эрхэлж буй хүн амын дийлэнх нь (эрэгтэйчүүдийн 77.8 хувь болон эмэгтэйчүүдийн 66.4 хувь) ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт ажиллаж байгаа нь мөн л мал аж, ахуй эрхэлж амьдралаа залгуулдагтай холбоотой. Дэлгэрэнгүйг хүснэгтээс харж болно.

Хүснэгт ЗВ. 7. Өдрийн тэмдэглэл хөтөлсөн 15, түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлдэг хүн амын эзлэх хувь, ажиллаж буй эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, хот, хөдөө, хүйсээр, Монгол Улс, 2019 он

Эдийн засгийн салбар	Хот		Хөдөө		Улсын дундаж	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	4.9	3.3	77.8	66.4	39.6	30.6
Уул уурхай, олборлолт	1.6	0.4	0.8	0.5	1.2	0.5
Боловсруулах үйлдвэрлэл	9.7	11.2	1.8	1.8	5.9	7.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	2.7	1.2	1.3	0.0	2.1	0.7
Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.8	0.8	0.1	0.2	0.5	0.5
Барилга	14.8	3.5	1.0	0.3	8.2	2.1
Бөөний болон жижиглэн худалдаа; Машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	16.5	19.6	2.9	5.1	10.0	13.3
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	12.1	2.2	1.7	0.3	7.2	1.4
Зочид буудал, байр, сууц, болон нийтийн хоолны үйлчилгээ	3.6	8.2	0.3	1.9	2.0	5.5
Мэдээлэл холбоо	3.1	2.0	0.2	0.1	1.7	1.2
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2.1	3.1	0.6	1.2	1.4	2.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.4	0.3	0.0	0.0	0.2	0.2
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2.2	1.5	0.4	0.7	1.3	1.1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2.3	2.8	0.1	0.1	1.2	1.6
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	13.4	12.3	6.5	6.1	10.1	9.6
Боловсрол	4.8	15.8	2.7	10.2	3.8	13.4
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	2.3	6.8	1.0	4.0	1.7	5.6
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.8	1.7	0.3	0.7	0.5	1.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.6	3.2	0.4	0.4	1.0	2.0
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа; Өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн, нэр төрлөөр нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.4	0.0	0.1	0.0	0.3	0.0
<b>Дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхэлдэг хүн амын тоо	961	1,166	880	894	1,841	2,060

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ХҮН АМЫН ЦАГ АШИГЛАЛТ

Хүн амын цаг ашиглалтын дүр зургийг гаргахдаа цаг ашиглалтын статистикт зориулсан олон улсын үйл ажиллагааны ангиллын дагуу тодорхой үйл ажиллагаануудад нэг өдөрт зарцуулсан дундаж минутаар буюу нийлбэр дүн нь 1,440 минут байхаар тооцсон. Ялгаатай байдлыг харах үүднээс тодорхой үйл ажиллагаанд зарцуулж буй дундаж хугацааг долоо хоногийн нэг өдөр, ажлын нэг өдөр, амралтын нэг өдөр гэж тусад нь тооцов. Бүх үйл ажиллагааг дараах байдлаар багцлан тооцсон бөгөөд үйл ажиллагааны ангиллыг хавсралт В-ээс дэлгэрэнгүй харж болно.

- Үндэсний тооцооны систем (ҮТС)-ийн хүрээний үйл ажиллагаа буюу хөлстэй хөдөлмөр эрхлэх
- ҮТС-ийн өргөтгөсөн хүрээний үйл ажиллагаа буюу хөлсгүй хөдөлмөр эрхлэх
- ҮТС-ийн хүрээний бус үйл ажиллагаа буюу өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

Хүн амын цаг ашиглалтын байдлыг судалгаанд хамрагдсан нийт хүн амын хувьд буюу 12, түүнээс дээш насны хүн амын хувьд тооцож шинж байдлаар задлан энэхүү бүлэгт тайлбарласан. Үүнээс гадна амьдралын мөчлөг хэлбэрээр 5 насны бүлэг болгон дэлгэрүүлж энэхүү тайлангийн хавсралт А-д оруулсан. Дараах насны бүлгээр хавсралтыг бэлтгэв.

1. 12-17 насны хүүхэд
2. 18-24 насны залуучууд
3. 25-39 насны хүн ам
4. 40-59 насны хүн ам
5. 60, түүнээс дээш насны ахмадууд

Тайлангийн зарим хүснэгтэд өмнөх оны судалгаануудын үр дүнг харьцуулж оруулсан. Гэхдээ өмнөх судалгаануудын үр дүнг тооцохдоо түүврийн жин тооцож тархаагаагүй зөвхөн судалгаанд хамрагдсан хүн амын хувьд тооцсон тул шууд харьцуулахдаа анхаарна уу.

### **А. Ерөнхий төлөв**

Монгол хүний амьдралын хэв маяг, цаг ашиглалтын байдлыг зураг 4А.1, 4А.2-д харуулав. 2019 оны байдлаар улсын дунджаар Монгол хүн долоо хоногийн нэг өдөрт хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд 685 минут, хөдөлмөр эрхлэхэд 203 минут, чөлөөт цаг, урлаг спортын үйл ажиллагаанд 165 минут, гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд цалин хөлсгүй туслахад 155 минут, өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 105 минут зарцуулж байна. Харин өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах, боловсрол, сургалтын үйл ажиллагаа, олон нийтийн арга хэмжээ болон соёлын зан үйлд оролцох, цалин хөлсгүй сайн дурын ажил, сургалт зэрэг бусад үйл ажиллагаа тус бүрд дунджаар 9-50 минут зарцуулж байгааг зураг 4А.1-ээс харж болно.

Зураг 4А. 1. Долоо хоногийн 1 өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын цаг ашиглалтын ерөнхий дүр зураг, үйл ажиллагаа тус бүрээр, түүнд зарцуулсан минутаар, 2019 он




Зураг 4А.2-оос 12, түүнээс дээш насны хүн амын 1 өдрийн амьдралын хэв маягийг 24 цагаар харуулсан. Монгол Улсын 12, түүнээс дээш насны нийт хүн амын 39 хувь нь 7-8 цагийн хооронд, харин 88 хувь нь 23-24 цагийн хооронд унтаж байна. Хүн амын 12 хувь нь 12-13, 17 хувь нь 13-14 цагийн хооронд өдрийн хоолоо иддэг байна. Харин оройн хоолны хувьд 18 хувь нь 19-20, 14 хувь нь 18-19, 10 хувь нь 20-21 цагийн хооронд иддэг ажээ. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг оройн цагаар тэр дундаа 20-22 цагийн хооронд нийт хүн амын 34-36 хувь нь ашиглажээ.

Хөлсгүй хөдөлмөрийг авч үзвэл өглөөний 7 цагаас оройны 21 цаг хүртэл нийт хүн амын 13-24 хувь нь тогтмол гэрийн ажил хийдэг нь харагдаж байлаа. Мөн өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад 7-22 цагийн хооронд нийт хүн амын 4-6 хувь нь мөн тасралтгүйгээр цагаа зарцуулжээ.

Өдрийн 8-19 цагийн хооронд хүн амын нэлээдгүй хувь нь хөлстэй хөдөлмөрт цагаа зарцуулж байна. Тодруулбал, энэ хугацаанд 12, түүнээс дээш насны нийт хүн амын 18-29 хувь нь хөдөлмөр эрхэлж байхад 13-18 хувь нь өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл хийж байв.

Зураг 4А. 2. 12, түүнээс дээш насны хүн амын 1 өдрийн амьдралын хэв маяг, 24 цагаар, үйл ажиллагаагаар, дүнд эзлэх хувиар, Монгол Улс, 2019 он



Хөлстэй, хөлсгүй хөдөлмөр болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулж буй цаг нь хот, хөдөөгөөр ялгаатай хэвээр байгааг хүснэгт 4А.1-ээс харж болно. Тодруулбал, аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхлэхэд хотод амьдардаг 12, түүнээс дээш насны хүн ам долоо хоногийн 1 өдөрт дунджаар 240 минут, өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 21 минут зарцуулж байхад хөдөөгийн хүн амын хувьд аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхлэхэд 138 минут, харин өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 249 минутыг зарцуулдаг байна. Энэ нь хөдөөгийн хүн ам мал аж ахуй эрхэлж амьдралаа залгуулдагтай шууд холбоотой юм. Мөн хот, хөдөөгийн хүн амын хувьд өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах, боловсрол, сургалтын үйл ажиллагаа, чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд зарцуулж буй цагууд ялгаатай байгааг харж болно.


Өмнөх онуудтай харьцуулахад хотын хүн амын хувьд өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад зарцуулах цаг нэмэгдэж байна. Харин чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа болон цалин хөлсгүй, сайн дурын ажилд зарцуулах цаг хот, хөдөөгийн хүн амын аль алины хувьд өсчээ. Бусад үйл ажиллагааны хувьд 2011 онтой харьцуулахад өссөн ч, 2015 онтой харьцуулахад буурсан эсвэл үүний эсрэгээр байлаа.

Хүснэгт 4А. 1. Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хот хөдөөгөөр, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	2011*		2015*		2019	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
<b>Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа</b>	<b>251</b>	<b>337</b>	<b>268</b>	<b>379</b>	<b>261</b>	<b>387</b>
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа					240	138
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх					21	249
<b>Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа</b>	<b>216</b>	<b>233</b>	<b>188</b>	<b>183</b>	<b>227</b>	<b>191</b>
Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд цалин хөлсгүй туслах, үйлчилгээ үзүүлэх	166	196	140	147	155	156
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	44	31	46	31	62	29
Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	6	6	2	5	11	7
<b>Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа</b>	<b>973</b>	<b>870</b>	<b>984</b>	<b>878</b>	<b>952</b>	<b>862</b>
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	61	21	46	25	49	20
Олон нийтийн арга хэмжээ болон шашны зан үйлд оролцох	73	64	27	24	32	29
Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	130	93	156	126	178	141
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	709	692	755	703	693	672
<b>Дүн</b>	<b>1,440</b>	<b>1,440</b>	<b>1,440</b>	<b>1,440</b>	<b>1,440</b>	<b>1,440</b>

Ажлын болон амралтын өдрийн ялгаатай байдлыг Зураг 4А.3-т харуулсан. Ажлын өдөр буюу Даваагаас Баасан гарагт байгууллагууд болон сургууль, сургалтын төвүүд үйл ажиллагаа явуулдагтай уялдаад 12, түүнээс дээш насны хүн амын хувьд ажлын өдөр хөдөлмөр эрхлэх болон боловсрол, сургалтын үйл ажиллагаанд амралтын өдөртэй харьцуулахад илүү цаг зарцуулж байна. Харин үүний эсрэгээр амралтын өдөрт гэрийн ажил, чөлөөт, цаг, урлаг, спорт болон хувийн хэрэгцээндээ зарцуулах цаг нь ажлын өдрийнхөөс их байна.

Зураг 4А. 3. Ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, Монгол Улс, 2019 он




Цаг ашиглалтын судалгааг зохион байгуулсан онуудаар долоо хоногийн нэг өдөрт хөлстэй, хөлсгүй хөдөлмөр болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулж буй дундаж минутыг хүйсээр зураг 4А.4-т харууллаа. 2019 оны байдлаар Монгол Улсын 12, түүнээс дээш насны эрэгтэйчүүд 1 өдрийн 1,440 минутаасаа 385 минутыг хөлстэй хөдөлмөрт, 117 минутыг хөлсгүй хөдөлмөрт, үлдсэн 938 минутыг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулжээ. Харин эмэгтэйчүүдийн хувьд 1 өдрийнхөө 253 минутыг хөлстэй хөдөлмөрт, 281 минутыг хөлсгүй хөдөлмөрт, 906 минутыг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулдаг байна. Энэ нь нийгэмд нийтлэг яригддаг эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад хөлсгүй хөдөлмөрт их цагийг харин хөлстэй хөдөлмөрт бага цагийг зарцуулдаг хэмээх дүр тоо мэдээлэл, статистикаар баталгаажуулж байна.

Өмнөх судалгаануудын үр дүнтэй харьцуулахад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алиных нь хувьд хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй дундаж хугацаа 2015 оныхоос буурсан ч 2007 болон 2011 онтой харьцуулахад өндөр байв. Харин хөлсгүй хөдөлмөрт



зарцуулсан хугацааны хувьд эсрэгээрээ буюу 2015 оны судалгааныхаас өссөн хэдий ч 2007 болон 2011 оны судалгааны үр дүнгээс доогуур түвшинд байна.

Зураг 4А. 4. Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүйсээр, Монгол Улс, 2007, 2011, 2015, 2019 он



\* 2007, 2011, 2015 оны ЦАС-ны үр дүнг тооцоход жин ашиглаагүй бөгөөд судалгаанд хамрагдсан хүн амын хувьд тооцсон.

12, түүнээс дээш насны эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд хөлстэй, хөлсгүй хөдөлмөр болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацааг долоо хоногийн, ажлын болон амралтын өдрөөр нь өмнөх судалгаануудын оноор хүснэгт 4А.2-т дэлгэрэнгүй харуулсан.

Хүснэгт 4А. 2. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан минут, хүйсээр, Монгол Улс, 2007, 2011, 2015, 2019 он

Үйл ажиллагаа	2007*		2011*		2015*		2019	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Долоо хоногийн 1 өдөрт</b>								
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	354	243	348	238	391	266	385	253
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	124	288	139	290	97	256	117	281
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	962	909	953	912	952	918	938	906
<b>Ажлын 1 өдөрт</b>								
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	365	253	359	255	401	283	401	275
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	126	280	133	276	94	246	114	270
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	949	907	948	909	945	911	925	895
<b>Амралтын 1 өдөрт</b>								
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	339	229	322	193	363	222	340	197
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	123	300	152	322	107	281	127	308
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	978	911	966	966	970	937	973	935

Хүснэгт 4А.3-т байршил болон хүйсээр хүн амын цаг ашиглалтын байдал хэрхэн ялгаатай байгааг харуулсан. Төвөөс алслагдах тусам ААНБ, төрийн болон төрийн бус байгууллагад хөдөлмөр эрхлэх нь буурч харин өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлд зарцуулах цаг өсөж байна. Эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй цаг эрэгтэйчүүдийнхээс бага байгаа нь аль ч газар нийтлэг адил байгааг харж болно. Үүний эсрэгээр хөлсгүй хөдөлмөр тэр дундаа гэрийн ажил болон өрхийн гишүүдийг асрах ажилд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү цаг хугацааг зарцуулж байгаа нь байршлаар ялгаагүй байгаа юм.

Аймгийн төвийн хүмүүс өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд бусдаасаа илүү цаг зарцуулдаг байна. Тодруулбал, дээрх үйл ажиллагаанд аймгийн төвийн эрэгтэйчүүд нэг өдрийнхөө 1,009 минут, эмэгтэйчүүд 939 минутыг зарцуулж байгаа нь бусад байршилтай харьцуулахад 7-191 минутаар илүү байгаа юм. Боловсрол сургалтын үйл ажиллагаа болон чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд нийслэлийнхэн, харин олон нийтийн арга хэмжээ болон шашны зан үйлд оролцох болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд аймгийн төвийнхөн бусдаасаа илүү цагийг зарцуулж байлаа.

Хүснэгт 4А. 3. Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, хүйс, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	Нийслэл		Аймгийн төв		Сумын төв		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа</b>	<b>333</b>	<b>219</b>	<b>293</b>	<b>234</b>	<b>316</b>	<b>232</b>	<b>554</b>	<b>374</b>
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	320	210	228	195	209	172	107	109
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	13	10	65	39	108	60	448	265
<b>Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа</b>	<b>136</b>	<b>288</b>	<b>138</b>	<b>267</b>	<b>134</b>	<b>294</b>	<b>68</b>	<b>264</b>
Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд цалин хөлсгүй туслах, үйлчилгээ үзүүлэх	89	191	97	204	95	235	57	225
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	37	88	25	52	24	53	6	35
Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	10	10	16	11	15	6	5	5
<b>Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа</b>	<b>971</b>	<b>932</b>	<b>1,009</b>	<b>939</b>	<b>990</b>	<b>914</b>	<b>818</b>	<b>802</b>
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	63	48	38	34	40	27	12	13
Олон нийтийн арга хэмжээ болон шашны зан үйлд оролцох	24	31	45	40	41	33	24	24
Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	203	165	200	158	199	164	126	110
Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	681	688	728	707	709	690	657	655
<b>Дүн</b>	<b>1,440</b>	<b>1,440</b>	<b>1,440</b>	<b>1,440</b>	<b>1,440</b>	<b>1,440</b>	<b>1,440</b>	<b>1,440</b>


Зураг 4А.5-д хүн амын цаг ашиглалтын ерөнхий дүр зургийг насны бүлгээр ялгаатай байгааг харуулав. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийн ялгаатай байдал нь хүүхэд байхаас нь эхэлж байна. Энэ нь мэдээж нийгмийн дунд байдаг охид, эмэгтэйчүүд гэрийн ажил хийх ёстой, гэрийнхнийгээ асрах ёстой гэсэн нийтлэг ойлголттой шууд хамааралтай юм.

12-19 насныхны дийлэнх нь оюутан, сурагчид тул өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулж буй хугацааны дүнд эзлэх хувь нь бусдаас 23.7-29.5 пунктээр өндөр байна.

Хөлстэй хөдөлмөрт 30-39 насны эрэгтэйчүүд, 40-49 насны эмэгтэйчүүд хамгийн их цагаа зарцуулж байна. Эмэгтэйчүүдийн хувьд 20-49 насандаа нас ахих тусам хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг нь нэмэгдэж байгаа нь хүүхдүүд нь том болж гараас гардагтай холбоотой байж магадгүй юм.

Хөлсгүй хөдөлмөрийг авч үзэхэд 30-39 насны эмэгтэйчүүд өдрийн 24 цагийнхаа 22.3 хувийг, харин 50, түүнээс дээш насны эрэгтэйчүүд 10.2 хувийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулдаг байна. Эрэгтэйчүүдийн хувьд нас ахих тусам хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг нь нэмэгдэж байв.

Зураг 4А. 5. Долоо хоногийн 1 өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, насны бүлэг, хүйсээр, дүнд эзлэх хувиар, Монгол Улс, 2007, 2011, 2015, 2019 он



Хүн амын цаг ашиглалтын байдлыг насны бүлгээр ажлын болон амралтын өдрөөр тооцож хүснэгт 4А.4-д харууллаа. Хүснэгтээс харахад 60, түүнээс дээш насны хүн амын хувьд ажлын болон амралтын өдрийн ялгаа багатай, харин бусад насныхны хувьд хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулж буй цагт ажлын болон амралтын өдрийн ялгаа их байна.

Хүснэгт 4А. 4. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, насны бүлгээр, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	12-19	20-29	30-39	40-49	50-59	60+
<b>Долоо хоногийн 1 өдөр</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	73	325	380	418	339	148
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	120	227	232	194	227	252
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,247	888	827	827	874	1,041
<b>Ажлын нэг өдөр</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	74	348	409	447	355	151
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	106	217	227	185	221	250
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,259	875	804	808	864	1,039
<b>Амралтын нэг өдөр</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	70	265	304	341	296	139
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	158	254	248	219	244	256
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,213	922	888	880	900	1,045

Монгол Улсын 12, түүнээс дээш насны хүн амын цаг ашиглалтын байдлыг насны бүлэг, байршлаар хэр ялгаатайг харах зорилгоор хүснэгт 4А.5-ыг тооцсон. Байршлаар хүн амын цаг ашиглалтын байдал ялгаатай байгаа нь харагдаж байв. Хөдөөгийн багийн хүн амын хувьд хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй цаг нь аль ч насны бүлгийн хувьд бусад хүн амтай харьцуулахад өндөр байгаа нь мал ахуй эрхэлж өрхийн хэрэглээ, амьжиргаагаа залгуулдагтай холбоотой юм. Хөдөөгийн багийн 12-19 болон 60, түүнээс


дээш насныхны хувьд нийслэл, аймгийн төв болон сумын төвд амьдардаг энэ насныхнаас 2.6-4.9 дахин илүү хугацааг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байна.

Хүснэгт 4А. 5. Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, насны бүлэг, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	12-19	20-29	30-39	40-49	50-59	60+
<b>Нийслэл</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	52	289	361	381	288	78
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	120	232	254	222	250	288
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,268	919	825	837	902	1,074
<b>Аймгийн төв</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	48	298	337	358	285	107
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	127	230	228	193	238	239
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,265	912	875	889	917	1,094
<b>Сумын төв</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	49	290	315	356	320	142
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	121	261	251	218	233	252
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,270	889	874	865	887	1,046
<b>Хөдөө</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	234	460	478	527	487	363
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	112	194	183	146	173	173
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,094	787	779	767	780	904

Хүн амын цаг ашиглалтын ерөнхий дүр зургийг боловсролын түвшнээр нь зураг 4А.6-д харуулсан. Боловсролын түвшин нэмэгдэх тусам хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрт зарцуулах хугацаа нэмэгдэж байхад өөрийгөө хөгжүүлэх болон чөлөөт цагийн үйл ажиллагаанд зарцуулсан цаг буурч байна. Дээд боловсролтой хүн амын хувьд хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй дундаж хугацаа нь 317 минут байгаа нь бүрэн дунд боловсролтой хүн амынхтай тэнцүү, харин техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн амтай харьцуулахад 13 минутаар бага байгаа нь анхаарал татаж байгаа юм. Энэ нь хөлстэй хөдөлмөрт өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, тэр дундаа мал аж ахуй орж байгаатай холбоотой байх магадлалтай.

Зураг 4А. 6. Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, боловсролын түвшнээр, Монгол Улс, 2019 он



Хүснэгт 4А.6-д Монгол Улсын 12, түүнээс дээш насны хүн амын цаг ашиглалтын байдлыг боловсролын түвшнээр, ажлын болон амралтын өдрөөр харуулсан. Хүн амын боловсролын түвшин нэмэгдэх тусам ажлын өдөр хөлстэй хөдөлмөрт зарцуулж байгаа цаг өсч байна. Тухайлбал, ажлын өдөр хөлстэй хөдөлмөрт боловсролгүй эсвэл бага боловсролтой хүн ам 264 минут зарцуулж байхад дээд боловсролтой хүн ам 368 минут буюу 104 минутаар илүү хугацааг зарцуулжээ.

Харин амралтын өдөр бүрэн дунд боловсролтой хүмүүс хөлстэй хөдөлмөрт бусдаасаа илүү хугацааг зарцуулдаг байна.

Хүн амын боловсролын түвшин дээшлэх тусам хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй дундаж хугацаа нэмэгдэж байгаа нь ажлын эсвэл амралтын өдрөөр ялгаагүй байдаг нь хүснэгтээс харагдаж байлаа. Жишээ нь, амралтын өдөр хөлсгүй хөдөлмөрт боловсролгүй эсвэл бага боловсролтой хүмүүс 177 минут зарцуулж байхад дээд боловсролтой хүмүүс 288 минутыг зарцуулжээ.

Хүснэгт 4А. 6. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшнээр, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	Боловсролгүй, бага боловсролтой	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Дээд
<b>Долоо хоногийн нэг өдөр</b>					
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	265	291	317	330	317
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	164	182	224	229	243
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,011	967	899	882	880
<b>Ажлын нэг өдөр</b>					
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	264	297	326	349	368
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	160	175	223	224	225
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,016	968	891	867	846
<b>Амралтын нэг өдөр</b>					
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	268	275	290	280	187
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	177	201	227	241	288
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	995	964	923	919	965

Хүснэгт 4А.7-д долоо хоногийн 1 өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын цаг ашиглалтын байдлыг боловсролын түвшин, хүйс, байршлаар харууллаа. Боловсролын түвшин болон амьдарч буй байршлаас хамаарч хүн амын цаг ашиглалтын байдал ялгаатай байна. Тодруулбал, хөдөөгийн багт амьдардаг хүн амын хувьд долоо хоногийн 1 өдрийн цаг ашиглалтын байдал боловсролын түвшнээр төдийлөн ялгаагүй байв. Харин нийслэлд амьдардаг хүн амын хувьд боловсролгүй эсвэл бага, суурь боловсролтой хүн амын хувьд хөлстэй хөдөлмөр эрхлэлтэд зарцуулж буй цаг нь дээгүүр боловсролтой хүн амынхаас хамаагүй бага буюу зөрүү ихтэй (182-310 минут) байгааг харж болно. Аймгийн болон сумын төвд амьдардаг хүн амын амьдралын хэв маяг боловсролын түвшнээр ялгаатай байгаа дүр зураг нь төстэй байна.

Хөлстэй хөдөлмөрт нийслэлийн дээд боловсролтой эрэгтэйчүүд (410 минут), техникийн болон мэргэжлийн боловсролтой эмэгтэйчүүд (268), аймгийн болон сумын төвийн дээд боловсролтой эрэгтэйчүүд (харгалзан 351, 417 минут), эмэгтэйчүүд (харгалзан 298, 297 минут) хөлстэй хөдөлмөрт хамгийн их цаг зарцуулжээ. Харин хөдөөгийн эрэгтэйчүүдийн хувьд хөлстэй хөдөлмөрт зарцуулсан цаг боловсролын түвшнээр зөрүү багатай буюу 507-598 цагийг зарцуулж байна.

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийн зөрүү төвөөс алслагдах тусам өсч байгааг харж болно. Жишээ нь нийслэлд амьдардаг эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1.7-2.4 дахин илүү цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байхад энэхүү харьцаа нь хөдөөд 2.8-4.3 байна.

Хүснэгт 4А. 7. Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшин, хүйс, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	Боловсролгүй, бага боловсролтой		Суурь		Бүрэн дунд		Техникийн болон мэргэжлийн		Дээд	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Нийслэл</b>										
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	121	29	100	76	358	221	387	268	410	258
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	105	182	109	246	123	297	168	294	141	306
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,214	1,229	1,231	1,119	958	922	885	878	889	876
<b>Аймгийн төв</b>										
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	202	92	214	182	331	252	319	220	351	298
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	120	238	146	266	150	269	136	286	132	266
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,119	1,110	1,079	992	959	919	985	933	957	876
<b>Сумын төв</b>										
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	188	97	295	191	349	270	320	251	417	297
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	93	269	129	305	140	319	177	306	119	277
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,159	1,074	1,016	944	951	851	943	883	904	865
<b>Хөдөө</b>										
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	526	318	568	393	568	397	598	450	507	333
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	66	267	66	244	64	275	71	243	109	309
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	848	855	806	803	807	768	771	747	823	798

Хүн амын цаг ашиглалтын байдлыг эдийн засгийн үйл ажиллагаанд оруулж буй хувь нэмэр гэсэн утгаар нь харахад хөдөлмөр эрхэлдэг эсэхээр нь авч үзэх нь чухал юм. Өмнө дурдсанчлан хөдөлмөр эрхлэлтийн асуултыг хөдөлмөрийн насны буюу 15, түүнээс дээш насны хүнээс асуусан.

Зураг 4А.7-оос харахад долоо хоногийн 1 өдөрт хөдөлмөр эрхэлдэг хүн амын хувьд хөлстэй хөдөлмөр эрхлэхэд зарцуулдаг дундаж хугацаа нь 473 минут буюу 7.9 цаг байхад хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд 46 минут буюу ердөө 0.8 цаг байлаа. Харин хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цаг нь хөдөлмөр эрхэлдэг хүн амтай харьцуулахад 2 дахин их буюу өдөрт дунджаар 322 минут буюу 5.4 цагийг зарцуулдаг байна. Өрхийн хувьд ажил хийдэггүй гэртээ байдаг хүмүүс нь гэрийн ажил болон өрхийн гишүүдийг асрах асуудлыг хариуцдагтай холбоотой юм.

Хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд хөлстэй хөдөлмөрт зарцуулсан хугацаа гарсан байгаа нь дараах шалтгаантай. Нэгт, хөдөлмөр эрхлэлтийн байдлыг тодорхойлохдоо сүүлийн 7 хоног гэсэн хугацааг ашигладаг. Харин цаг ашиглалтын судалгааны хувьд өрх болон хувь хүний асуулгыг асуусны дараах 2-3 өдөрт өдрийн тэмдэглэлийг хөтлүүлдэг. Тиймээс, өрхийн асуулгыг авсны дараа өдрийн тэмдэглэл хөтөлж байх үед тухайн хүн



ажилд орсон байж болно. Хоёрт, ажил хайж явах нь хөлстэй хөдөлмөр эрхлэх гэсэн бүлэгт хамаардаг. Гуравдугаарт, хөдөлмөр эрхэлдэггүй хэдий ч богино хугацааны түр зуурын ажил өдрийн тэмдэглэл хөтлөх хугацаанд хийсэн тохиолдлууд байж болох юм.

Хөдөлмөр эрхэлдэг хүн амын хувьд хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цаг нь ажлын болон амралтын өдрөөр нэлээдгүй ялгаатай байхад хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд ижил дүр зурагтай байгааг мөн харж болно.

Зураг 4А. 7. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хөдөлмөр эрхэлдэг эсэхээр, Монгол Улс, 2019 он



Цаг ашиглалтын байдлыг хөдөлмөр эрхэлдэг эсэхээс гадна хүйсээр нь хүснэгт 4А.8-д харууллаа. 15, түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлдэг эрэгтэйчүүд хөлстэй хөдөлмөр эрхлэхэд ажлын нэг өдөр 544 минут зарцуулж байгаа нь хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийнхээс 73 минутаар илүү байв. Харин хөдөлмөр эрхэлдэг эрэгтэйчүүд ажлын нэг өдөр хөлсгүй хөдөлмөрт 90 минут зарцуулж байгаа нь эмэгтэйчүүдийнхээс 204 минутаар буюу 2.3 дахин бага үзүүлэлттэй гарсан.

Амралтын өдөр эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийн зөрүүтэй байдал нь ажлын өдөртэй харьцуулахад нэмэгдэж байв. Тодруулбал, хөдөлмөр эрхэлдэг эрэгтэйчүүд амралтын өдөр хөлстэй хөдөлмөрт 454 цагийг зарцуулж байгаа нь эмэгтэйчүүдийнхээс 126 минутаар илүү, харин эрэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цаг нь 104 минут байгаа нь эмэгтэйчүүдийнхээс 162 минутаар бага байгаа юм.

Дээрх үзүүлэлтүүд нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй адил хөдөлмөр эрхэлж карьер хөөж амжилтад хүрэхэд учирдаг тэгш бус байдлуудын нэг юм.

Хүснэгт 4А. 8. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, хөдөлмөр эхэлдэг эсэхээр, хүйсээр, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	Эрэгтэй		Эмэгтэй		Улсын дундаж	
	Хөдөлмөр		Хөдөлмөр		Хөдөлмөр	
	эрхэл- дэг	эрхэлдэг- гүй	эрхэл- дэг	эрхэлдэг- гүй	эрхэл- дэг	эрхэлдэг- гүй
<b>Долоо хоногийн 1 өдөр</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	519	67	432	37	473	46
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	94	194	221	374	161	322
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	827	1,179	788	1,029	806	1,073
<b>Ажлын нэг өдөр</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	544	64	471	37	505	45
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	90	192	204	375	150	321
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	806	1,184	765	1,029	784	1,074
<b>Амралтын нэг өдөр</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	454	73	328	39	387	49
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	104	199	266	372	190	322
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	881	1,167	846	1,030	863	1,069

Байршлаас хамаарч хөдөлмөр эрхэлдэг болон эрхэлдэггүй хүмүүсийн цаг ашиглалтын байдалд хэр өөрчлөлт гарч байгааг харах зорилгоор хүснэгт 4А.9-ийг тооцсон. Хөдөлмөр эрхэлдэг хүн амын хувьд байршлаар харагдаж буй цаг ашиглалтын дүр зураг нь хүйсээр ялгаатай байв. Тодруулбал, хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийн хувьд хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй цаг нь нийслэлээс сумын төв хүртэл алслагдах тусам нэмэгдэж байгаа ч хөдөөгийн эмэгтэйчүүдийн хувьд аймгийн төвийн түвшинтэй ойролцоо байлаа. Харин эрэгтэйчүүдийн хувьд нийслэлээс сумын төв хүртэл алслагдах тусам хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг буурч байгаа ч хөдөөгийн эрэгтэйчүүдийн хувьд хөлстэй хөдөлмөрт хамгийн их цагийг зарцуулж байв. Хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цаг хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийн хувьд төвөөс алслагдах тусам нэмэгдэж байлаа. Харин нийслэл, аймгийн болон сумын төвийн хөдөлмөр эрхэлдэг эрэгтэйчүүдийн хувьд хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цаг нь төдийлөн ялгаа багатай 108-119 минут байхад хөдөөгийн эрэгтэйчүүдийн хувьд 63 минут байгаа юм.

Төвөөс алслагдах тусам хөдөлмөр эрхэлдэг болон эрхэлдэггүй эмэгтэйчүүдийн гэрийн ажилд зарцуулах цагийн зөрүү буурч байна. Өөрөөр хэлбэл, нийслэлд амьдардаг хөдөлмөр эрхэлдэггүй эмэгтэйчүүд хөлсгүй хөдөлмөрт өдрийн 1,440 минутаасаа 393 минутыг зарцуулж байхад хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүд 188 минут зарцуулж, зөрүү нь 205 минут байв. Харин хөдөөгийн хөдөлмөр эрхэлдэггүй эмэгтэйчүүд 306 минутыг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байгаа нь хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдтэй харьцуулахад 48 минутаар илүү байлаа.

Хүснэгт 4А. 9. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, хөдөлмөр эхэлдэг эсэхээр, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	Эрэгтэй		Эмэгтэй		Улсын дундаж	
	Хөдөлмөр		Хөдөлмөр		Хөдөлмөр	
	эрхэл-дэг	эрхэлдэг-гүй	эрхэл-дэг	эрхэлдэг-гүй	эрхэл-дэг	эрхэлдэг-гүй
<b>Нийслэл</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	512	25	465	14	486	17
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	109	204	188	393	152	342
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	819	1,211	788	1,033	802	1,081
<b>Аймгийн төв</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	439	47	420	39	429	41
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	108	212	205	352	160	307
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	893	1,181	815	1,049	851	1,091
<b>Сумын төв</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	439	124	358	83	394	97
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	119	178	260	355	198	296
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	882	1,138	822	1,002	848	1,048
<b>Хөдөө</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	589	258	426	139	510	177
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	63	123	258	306	158	247
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	788	1,059	756	995	772	1,016

Дэлхийн улс орнууд Тогтвортой хөгжлийн зорилгыг хэлэлцэн батлахдаа “хэн ч хөгжлийн гадуур үлдэж болохгүй” гэсэн уриаг давхар дэвшүүлсэн билээ. Үүнтэй уялдаад аливаа хүн амын статистик тоо мэдээллийг маш олон задаргаагаар гаргах зорилгыг дэвшүүлсэн. Үүний нэг нь хүн амтай холбоотой аливаа үзүүлэлтийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр гаргах билээ.

Энэ удаагийн судалгаанд өмнөх бүлэгт дурдсанчлан хөгжлийн бэрхшээлийг үнэлэхдээ үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр тодорхойлсон. Ингээд хүн амын цаг ашиглалтын байдлыг үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр болон ажлын болон амралтын өдрөөр ялган зураг 4А.8-д харуулсан.

Үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр цаг ашиглалтын байдал ялгаатай байгаа нь зургаас харагдаж байна. Тодруулбал, 12, түүнээс дээш насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүний хувьд үйлдлийн чадварын ямар нэг хүндрэлгүй хүнтэй харьцуулахад хөлстэй хөдөлмөрт бага хугацааг, харин хөлсгүй хөдөлмөрт илүү хугацааг зарцуулж байв. Түүнчлэн, үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын хувьд өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулж буй цаг нь ажлын болон амралтын өдрөөр ялгаагүй буюу өдрийнхөө 1,027 минутыг зарцуулдаг байна.

Зураг 4А. 8. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан цаг, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, минутаар, Монгол Улс, 2019 он



Хүн амын цаг ашиглалтыг үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээс гадна хүйсээр, долоо хоногийн, ажлын болон амралтын өдрөөр хүснэгт 4А.10-д харууллаа. Үйлдлийн чадварын хүндрэлтэй эрэгтэйчүүдийн хувьд аль ч өдөр хөлстэй хөдөлмөрт зарцуулж байгаа дундаж хугацаа нь үйлдлийн чадварын хүндрэлгүй эрэгтэйчүүдтэй харьцуулахад доогуур түвшинд буюу 146-202 минутаар бага байна. Харин эрэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цаг нь үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээс хамаарч 39-45 минутын зөрүүтэй байгааг хүснэгтээс харж болно.

Эмэгтэйчүүдийн хувьд хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийн зөрүү үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр бараг ялгаагүй байв. Тодруулбал, үйлдлийн чадварын хүндрэлтэй эмэгтэйчүүдийн хувьд ажлын өдрүүдэд хөлсгүй хөдөлмөрт 282 минут зарцуулж байгаа нь үйлдлийн чадварын хүндрэлгүй эмэгтэйчүүдтэй харьцуулахад 12 минутаар их, харин амралтын өдрийн хувьд эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй дундаж хугацаа нь үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээс үл хамааран 308-309 минут байгаа юм. Харин эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй цагийг үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээс хамааруулж авч үзвэл ажлын өдөр 116 минут, амралтын өдөр 69 минутын зөрүүтэй байна.

Хүснэгт 4А. 10. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, хүйсээр, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	Эрэгтэй		Эмэгтэй		Улсын дундаж	
	Үйлдлийн чадварын		Үйлдлийн чадварын		Үйлдлийн чадварын	
	хүндрэл-гүй	хүндрэл-тэй	хүндрэл-гүй	хүндрэл-тэй	хүндрэл-гүй	хүндрэл-тэй
<b>Долоо хоногийн 1 өдөр</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	395	208	259	157	315	178
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	115	156	280	289	213	236
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	930	1,075	900	994	912	1,027
<b>Ажлын нэг өдөр</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	413	211	282	166	335	184
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	112	151	270	282	205	229
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	916	1,078	889	992	900	1,027
<b>Амралтын нэг өдөр</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	349	203	201	132	261	162
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	125	170	308	309	233	251
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	967	1,068	931	998	946	1,027

12, түүнээс дээш насны хүн амын долоо хоногийн 1 өдрийн цаг ашиглалтын байдлыг үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, хүйсээр, байршлаар хүснэгт 4А.11-д харуулсан. Хүснэгтээс харахад ялгаатай байдал ажиглагдаж байна. Тодруулбал, улсын хэмжээнд харахад нийслэлээс алслагдах тусам үйлдлийн чадварын хүндрэлтэй болон хүндрэлгүй хүн амын хөлстэй хөдөлмөрт зарцуулж байгаа цагийн зөрүү багасаж байна. Мөн төвөөс алслагдах тусам үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын хөлстэй хөдөлмөрт зарцуулж байгаа цаг нэмэгдэж байхад хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байгаа цаг буурч байгааг харж болно. Жишээ нь, нийслэл амьдардаг үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүс хөлстэй хөдөлмөрт 96 минутыг, хөлсгүй хөдөлмөрт 283 минутыг зарцуулж байхад хөдөө амьдардаг үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүс харгалзан 382 болон 167 минутыг зарцуулж байна.


Хүснэгт 4А. 11. Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, хүйсээр, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	Эрэгтэй		Эмэгтэй		Улсын дундаж	
	Үйлдлийн чадварын хүндрэлгүй	хүндрэлтэй	Үйлдлийн чадварын хүндрэлгүй	хүндрэлтэй	Үйлдлийн чадварын хүндрэлгүй	хүндрэлтэй
<b>Нийслэл</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	345	73	225	109	270	96
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	131	241	287	306	229	283
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	964	1,126	928	1,025	941	1,061
<b>Аймгийн төв</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	304	143	241	100	267	121
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	137	155	265	300	213	230
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	999	1,142	934	1,040	960	1,090
<b>Сумын төв</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	328	172	240	158	276	163
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	133	139	297	267	230	223
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	978	1,129	903	1,014	934	1,054
<b>Хөдөө</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	560	456	378	309	468	382
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	68	62	263	272	167	167
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	812	922	799	858	805	890

Цаг ашиглалтын 2019 оны судалгааны үр дүнг анх удаагаа гэрлэлтийн байдал болон хүүхдийн тоотой нь уялдуулан гаргасан. Гэрлэлтийн байдал болон хүүхэдтэй эсэх асуултуудыг 15, түүнээс дээш насны хүн амаас асуусан. Гэсэн хэдий ч хүн амын цаг ашиглалтыг гэрлэлтийн байдлаар болон хүүхэдтэй эсэхээр харуулахдаа 18, түүнээс дээш насны хүн амын хувьд тооцсон.

Хүн амын цаг ашиглалт гэрлэлтийн байдлаар ялгаатай байгааг Зураг 4А.9-д харуулав. 18, түүнээс дээш насны огт гэрлээгүй хүмүүсийн хувьд өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд, гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай хүн амын хувьд хөлстэй хөдөлмөр эрхлэхэд, харин тусгаарласан, цуцалсан эсвэл бэлэвсэн хүн амын хувьд хөлсгүй хөдөлмөрт бусдаас илүү цаг зарцуулжээ.

Зураг 4А. 9. Ажлын болон амралтын нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх болон өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, гэрлэлтийн байдлаар, Монгол Улс, 2019 он



18, түүнээс дээш насны хүн амын цаг ашиглалтын байдлыг гэрлэлтийн байдлаас гадна хүйсээр гаргаж хүснэгт 4А.12-д үзүүлэв. Хүснэгтээс харахад ажил, амралтын өдрөөс үл хамааран тусгаарласан, цуцалсан, бэлэвсэн эрэгтэйчүүд болон гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай эмэгтэйчүүд хөлсгүй хөдөлмөр буюу гэрийн ажил, өрхийн гишүүдийг асрах ажилд хамгийн их цагийг зарцуулдаг байна.

Хүснэгт 4А. 12. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, гэрлэлтийн байдал, хүйсээр, минутаар, Монгол улс, 2019 он

Үйл ажиллагаа	Эрэгтэй			Эмэгтэй		
	Огт гэрлээгүй	Гэрлэсэн/хамтран амьдрагчтай	Тусгаарласан/цуцалсан/бэлэвсэн	Огт гэрлээгүй	Гэрлэсэн/хамтран амьдрагчтай	Тусгаарласан/цуцалсан/бэлэвсэн
<b>Долоо хоногийн 1 өдөр</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	313	437	312	217	284	223
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	90	123	158	187	314	265
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,037	880	970	1,036	842	951
<b>Ажлын нэг өдөр</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	330	456	325	233	310	240
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	79	121	161	175	302	261
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,031	864	953	1,032	828	939
<b>Амралтын нэг өдөр</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	266	387	275	178	215	179
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	120	129	149	217	343	277
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,054	924	1,016	1,046	882	984

Хүснэгт 4А.13-т долоо хоногийн 1 өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын цаг ашиглалтын ерөнхий дүр зургийг гэрлэлтийн байдал, хүйс, байршлаар харуулсан. Нийслэлийн хувьд огт гэрлээгүй эмэгтэйчүүд, бусад байршлын хувьд гэрлэсэн, хамтран амьдрагчтай эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд хөлстэй хөдөлмөр эрхлэхэд бусдаасаа илүү цагийг зарцуулж байна.

Байршлаас үл хамааран тусгаарласан, цуцалсан эсвэл бэлэвсэн эрэгтэйчүүд, гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай эмэгтэйчүүд хөлсгүй хөдөлмөрт илүү цагийг зарцуулж байгаа нь хүснэгтээс харагдаж байлаа.

Ерөнхийдөө аймгийн төвөөс алслагдах тусам өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулж буй цаг нь хүйс болон гэрлэлтийн байдлыг үл хамааран буурч байв.



Хүснэгт 4А. 13. Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, гэрлэлтийн байдал, хүйс, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	Эрэгтэй			Эмэгтэй		
	Огт гэрлээгүй	Гэрлэсэн/хамтран амьдрагчтай	Тусгаарласан/цуцалсан/бэлэвсэн	Огт гэрлээгүй	Гэрлэсэн/хамтран амьдрагчтай	Тусгаарласан/цуцалсан/бэлэвсэн
<b>Нийслэл</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	322	398	291	301	238	209
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	84	153	163	165	340	273
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,034	888	986	974	862	958
<b>Аймгийн төв</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	292	347	189	230	263	224
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	121	141	198	245	295	239
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,027	952	1,054	966	882	977
<b>Сумын төв</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	353	355	299	192	278	172
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	148	140	159	310	301	311
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	939	945	982	938	861	956
<b>Хөдөө</b>						
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	572	582	441	348	394	344
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	73	61	120	227	282	210
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	795	797	880	865	764	887

Хүүхэдтэй эсэх, хүүхэдтэй бол хамт амьдарч байгаа 16 хүртэлх насны хүүхдийн тоо нь хүн амын цаг ашиглалтад хэрхэн нөлөөлж байгааг зураг 4А.10 болон хүснэгт 4А.14, 15-д харуулав. Зургаас харахад хамт амьдарч байгаа 16 хүртэлх насны хүүхдийн тоо нэмэгдэх тусам хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цаг нэмэгдэж байна. 16 хүртэлх насны 1-2 хүүхэдтэй хүмүүс хөлстэй хөдөлмөрт хамгийн их цагийг зарцуулжээ. Тодруулбал, эдгээр хүмүүс хөлстэй хөдөлмөрт ажлын өдөр 406 минут буюу 6.8 цаг, амралтын өдөр 304 минут буюу 5.1 цагийг зарцуулж байлаа.

Зураг 4А. 10. Ажлын болон амралтын нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж минут, хүүхэдтэй эсэхээр, хамт амьдардаг 16 хүртэлх насны хүүхдийн тоогоор, Монгол Улс, 2019 он



Хүснэгт 4А.14-өөс харахад эрэгтэйчүүдийн хувьд хамт амьдардаг 16 хүртэлх насны хүүхдийн тоо нь нэмэгдэх тусам хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй цаг нь нэмэгдэж байв. Харин эмэгтэйчүүдийн хувьд 1-2 хүүхэдтэй бол хөлстэй хөдөлмөрт хамгийн их цаг буюу долоо хоногийн нэг өдөрт дунджаар 318 минут зарцуулж байгаа ч хүүхдийн тоо нэмэгдэж 3, түүнээс олон хүүхэдтэй бол хамгийн бага буюу 236 минутыг хөлстэй хөдөлмөрт зарцуулжээ.

Хүүхэдтэй хэдий ч хамт амьдардаг 16 хүртэлх насны хүүхэдгүй эрэгтэйчүүд хөлсгүй хөдөлмөрт долоо хоногийн нэг өдөрт дунджаар 149 минут, хамт амьдардаг 3, түүнээс олон хүүхэдтэй эмэгтэйчүүд 404 минутыг зарцуулж байгаа нь хамгийн их хугацаа зарцуулдаг нь байлаа. Хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийг ажлын болон амралтын өдрөөр ялган авч үзэхэд эрэгтэйчүүдийн хувьд төдийлөн ялгаа багатай буюу 2-25 минутын зөрүүтэй байхад эмэгтэйчүүдийн хувьд 13-48 минутын зөрүүтэй байна.

Хүснэгт 4А. 14. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, хүүхэдтэй эсэхээр, хамт амьдардаг 16 хүртэлх насны хүүхдийн тоогоор, хүйсээр, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	Эрэгтэй				Эмэгтэй			
	Хүүхэд-гүй	Хүүхэдтэй эсэх			Хүүхэд-гүй	Хүүхэдтэй эсэх		
		Хүүхэдтэй				Хүүхэдтэй		
		Хамт амьдарч байгаа 16 хүртэлх насны хүүхдийн тоо				Хамт амьдарч байгаа 16 хүртэлх насны хүүхдийн тоо		
0	1-2	3+	0	1-2	3+			
<b>Долоо хоногийн 1 өдөр</b>								
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	401	350	480	487	249	246	318	236
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	101	149	106	121	203	275	293	404
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	938	941	854	832	989	920	829	800
<b>Ажлын нэг өдөр</b>								
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	423	362	502	512	269	264	349	257
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	94	146	106	118	189	266	280	401
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	923	932	832	811	982	910	811	782
<b>Амралтын нэг өдөр</b>								
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	343	322	421	412	197	199	237	175
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	119	156	108	133	237	297	327	414
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	978	962	911	895	1,005	944	877	852

18, түүнээс дээш насны эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн цаг ашиглалтын байдалд хүүхэдтэй эсэх, хэрэв хүүхэдтэй бол хамт амьдардаг 16 хүртэлх насны хүүхдийн тоо болон амьдарч буй байршил хэрхэн нөлөөлж байгааг хүснэгт 4А.15-д харуулав.

Хөдөөгийн эрэгтэйчүүдийн хувьд хүүхэдтэй эсэх, хүүхэдтэй бол хамт амьдардаг 16 хүртэлх насны хүүхдийн тоо амьдралын хэв маяг, цаг ашиглалтад нь төдийлөн нөлөө багатай байгаа нь харагдаж байна.

Нийслэлийн эрэгтэйчүүдийн хувьд 16 хүртэлх насны хүүхэдтэйгээ хамт амьдардаг бол (474-475 минут), аймгийн төвийн эрэгтэйчүүдийн хувьд 16 хүртэлх насны 1-2 хүүхэдтэйгээ хамт амьдардаг бол (421 минут), сумын төвийн эрэгтэйчүүдийн хувьд 16 хүртэлх насны 3, түүнээс олон хүүхэдтэйгээ хамт амьдардаг бол (435 минут) хөлстэй хөдөлмөрт бусдаасаа хамаагүй их цагийг зарцуулж байв. Эрэгтэйчүүдийн хувьд хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийн зөрүүтэй байдал нь байршлаар бага ажиглагдав.

16 хүртэлх насны хүүхдийн тоо нэмэгдэх тусам хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цаг нь аль ч байршлын хувьд адилхан нэмэгдэж байгаа нь хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 4А. 15. Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, хүүхэдтэй эсэхээр, хамт амьдардаг 16 хүртэлх насны хүүхдийн тоогоор, хүйсээр, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	Эрэгтэй				Эмэгтэй			
	Хүүхэд-гүй	Хүүхэдтэй эсэх			Хүүхэд-гүй	Хүүхэдтэй эсэх		
		Хүүхэдтэй				Хүүхэдтэй		
		Хамт амьдарч байгаа 16 хүртэлх насны хүүхдийн тоо				Хамт амьдарч байгаа 16 хүртэлх насны хүүхдийн тоо		
0	1-2	3+	0	1-2	3+			
<b>Нийслэл</b>								
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	330	258	474	475	229	195	299	194
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	103	188	126	149	176	294	299	442
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,007	994	840	816	1,036	951	841	804
<b>Аймгийн төв</b>								
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	269	264	421	385	240	207	311	244
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	118	174	119	128	206	266	277	364
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,053	1,003	900	927	994	967	852	831
<b>Сумын төв</b>								
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	333	331	347	435	183	237	273	258
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	145	151	134	136	279	289	312	352
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	962	958	958	869	978	914	854	830
<b>Хөдөө</b>								
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	558	553	590	584	371	396	401	320
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	77	75	54	64	232	231	275	370
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	805	812	796	792	836	813	765	750

## Б. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа

ҮТС-ийн хүрээний үйл ажиллагаа буюу хөлстэй хөдөлмөр гэдэгт аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхлэх, орлого олох зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх, өрхийн бизнест хөдөлмөр эрхлэх, мөн өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх ордог.

Хүснэгт 4Б.1-д 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй цагийг хүйсээр болон байршлаар, ажлын болон амралтын өдрөөр ялган харуулсан. Хүснэгтээс харахад төвөөс алслагдах тусам аж, ахуйн нэгж байгууллага (ААНБ), төрийн болон төрийн бус байгууллагад хөдөлмөр эрхлэх байдал багасаж түүнд зарцуулах цаг нь буурч байна. Үүний эсрэгээр төвөөс алслагдах тусам орлого олох зорилгоор эсвэл өрхийн эцсийн хэрэглээнд зориулж мал, аж ахуй эрхлэхэд зарцуулах цаг нь нэмэгдэж байгааг харж болно.

Ажлын өдөр ажилдаа явахад зарцуулдаг дундаж хугацааг харахад нийслэлд 31-45 минут байхад хөдөөд 4-5 минут байв.

Хүмүүс амралтын өдрүүдэд ч хөлстэй хөдөлмөр эрхэлж, тодорхой цаг хугацааг зарцуулж байна. Хөдөөгийн хүн амын хувьд мал аж ахуйгаа эрхэлж амьжиргаагаа залгуулдаг тул ажил, амралтын өдрөөс үл хамааран өрхийн хэрэглээнд зориулж мал маллахад эрэгтэйчүүд 397-404 минут, эмэгтэйчүүд 213-219 минутыг зарцуулдаг байна.

Төвөөс алслагдах тусам өрхийн хэрэглээнд зориулж ус, түлээ түлш бэлтгэхэд илүү хугацааг зарцуулж байна. Мөн амралтын өдөр усанд явах, түлээ түлш бэлтгэхэд илүү цагийг зарцуулж байгааг хүснэгтээс харж болно.

Хүснэгт 4Б. 1. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй хөдөлмөрт зарцуулсан дундаж хугацаа, хүйс, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	Нийслэл		Аймгийн төв		Сумын төв		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Долоо хоногийн 1 өдөр</b>	<b>333</b>	<b>219</b>	<b>293</b>	<b>234</b>	<b>316</b>	<b>232</b>	<b>554</b>	<b>374</b>
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	320	210	228	195	209	172	107	109
Үүнээс:								
Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	220	148	160	141	132	127	22	32
Орлого олох зорилгоор МАА эрхлэх	1	1	1	3	21	7	74	66
Ажилдаа явах, зорчих	41	28	16	18	15	14	4	4
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	13	10	65	39	108	60	448	265
Үүнээс:								
Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	2	1	44	20	69	27	402	217
Усанд явж, түлээ түлш бэлтгэх	9	6	13	10	25	17	23	31
<b>Ажлын 1 өдөр</b>	<b>358</b>	<b>244</b>	<b>313</b>	<b>265</b>	<b>332</b>	<b>259</b>	<b>556</b>	<b>377</b>
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	347	235	251	226	228	199	108	110
Үүнээс:								
Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	236	167	175	168	147	151	23	35
Орлого олох зорилгоор МАА эрхлэх	1	0	2	3	20	5	75	64
Ажилдаа явах, зорчих	45	31	19	21	17	17	4	5
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	12	9	62	38	104	60	448	267
Үүнээс:								
Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	2	1	42	19	69	28	404	219
Усанд явж, түлээ түлш бэлтгэх	8	5	13	10	23	17	23	30
<b>Амралтын 1 өдөр</b>	<b>264</b>	<b>155</b>	<b>239</b>	<b>155</b>	<b>276</b>	<b>161</b>	<b>549</b>	<b>366</b>
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	248	143	168	116	160	101	102	107
Үүнээс:								
Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	177	97	120	72	93	63	18	25
Орлого олох зорилгоор МАА эрхлэх	0	1	0	4	25	11	73	73
Ажилдаа явах, зорчих	31	20	10	11	12	8	3	3
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	15	12	72	39	116	60	446	258
Үүнээс:								
Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	2	1	47	21	70	27	397	213
Усанд явж, түлээ түлш бэлтгэх	11	7	15	12	32	19	22	32

Хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй дундаж хугацааг насны бүлгээр хүснэгт 4Б.2-д харуулав. Хүснэгтээс харахад долоо хоногийн 1 өдөрт хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй цаг 40-49 насны хүн амын (418 минут) дунд хамгийн их байв.

Ажлын нэг өдөрт аж ахуйн нэгж, байгууллагад ажиллахтай холбоотой зарцуулж буй дундаж хугацаа 20-49 насныхны хувьд хамгийн их буюу 192-210 минут зарцуулдаг

байна. Эдгээр үзүүлэлт нь энэ насны бүлгийн бүх хүний хувьд тооцсон дундаж үзүүлэлт гэдгийг анхаарна уу.

Өрхийн хэрэглээний түлээ түлш бэлтгэх, ус авахад 40, түүнээс дээш насныхан илүү цаг зарцуулдаг байна.

Хүснэгт 4Б. 2. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй хөдөлмөрт зарцуулсан дундаж хугацаа, насны бүлгээр, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	12-19	20-29	30-39	40-49	50-59	60+
<b>Долоо хоногийн 1 өдөр</b>	<b>73</b>	<b>325</b>	<b>380</b>	<b>418</b>	<b>339</b>	<b>148</b>
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	39	239	278	268	218	55
Үүнээс:						
Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	23	174	186	171	133	21
Орлого олох зорилгоор МАА эрхлэх	7	20	19	26	21	10
Ажилдаа явах, зорчих	5	27	30	28	21	3
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	34	86	102	150	121	93
Үүнээс:						
Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	23	71	81	125	91	60
Усанд явж, түлээ түлш бэлтгэх	9	11	11	16	17	19
<b>Ажлын 1 өдөр</b>	<b>74</b>	<b>348</b>	<b>409</b>	<b>447</b>	<b>355</b>	<b>151</b>
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	41	263	309	297	232	60
Үүнээс:						
Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	24	192	210	194	144	23
Орлого олох зорилгоор МАА эрхлэх	7	20	17	26	20	10
Ажилдаа явах, зорчих	6	30	34	31	24	4
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	33	84	100	149	123	91
Үүнээс:						
Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	22	71	80	124	94	60
Усанд явж, түлээ түлш бэлтгэх	8	10	11	16	17	18
<b>Амралтын 1 өдөр</b>	<b>70</b>	<b>265</b>	<b>304</b>	<b>341</b>	<b>296</b>	<b>139</b>
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	32	175	199	189	180	42
Үүнээс:						
Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	19	125	125	107	104	14
Орлого олох зорилгоор МАА эрхлэх	8	19	21	27	23	11
Ажилдаа явах, зорчих	3	21	20	19	15	2
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	37	90	105	152	116	97
Үүнээс:						
Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	24	72	83	126	84	62
Усанд явж, түлээ түлш бэлтгэх	12	13	13	17	19	21

Хүснэгт 4Б.3-г 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй цагийг боловсролын түвшнээр, ажлын болон амралтын өдрөөр харууллаа. Хүснэгтээс харахад боловсролын түвшин дээшлэх тусам ажлын өдөр хөлстэй хөдөлмөр эрхлэлтэд зарцуулж буй цаг нэмэгдэж байна. Харин амралтын өдөр хөлстэй хөдөлмөрт зарцуулсан хугацаа дээд боловсролтой хүн амын хувьд 187 минут байхад бусад хүмүүсийн хувьд 268-290 минут байгааг хүснэгтээс харж болно.

Хөдөлмөр эрхлэлтэд зарцуулж буй дундаж хугацаа боловсролын түвшинтэй шууд хамааралтай байхад өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлд зарцуулж буй дундаж хугацаа урвуу хамааралтай байна. Энэхүү дүр зураг нь ажлын болон амралтын өдөр ялгаагүй байна. Тухайлбал, бүрэн дунд түүнээс дээш боловсролтой хүн амын хувьд ААНБ, төрийн болон төрийн бус байгууллагад ажиллахтай холбоотой үйл ажиллагаанд долоо хоногийн нэг өдөрт зарцуулж буй дундаж

хугацаа 141-221 минут байхад суурь түүнээс доош боловсролтой хүн амын хувьд нэлээд бага буюу ердөө 20-41 минут байна.

Харин өрхийн хэрэглээнд зориулж мал маллахад зарцуулсан дундаж хугацаа бүрэн дунд түүнээс бага боловсролтой хүн амын дунд 163-167 минут байхад техникийн болон мэргэжлийн, дээд боловсролтой хүн амын хувьд дунджаар 13-73 минут байлаа.

Өрхийн хэрэглээнд зориулж ус, түлээ түлш бэлтгэхэд боловсролын түвшин буурах тусам илүү хугацааг зарцуулж байна. Энэ нь боловсролын түвшинтэй уялдаад өрхийн аж байдлын түвшин өөр байгаатай холбоотой.

Хүснэгт 4Б. 3. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд өдөрт зарцуулсан дундаж хугацаа, боловсролын түвшнээр, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	Боловсролгүй, бага боловсролтой	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Дээд
<b>Долоо хоногийн 1 өдөр</b>	<b>265</b>	<b>291</b>	<b>317</b>	<b>330</b>	<b>317</b>
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	63	95	220	265	293
Үүнээс:					
Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	20	41	141	162	221
Орлого олох зорилгоор МАА эрхлэх	31	30	18	21	3
Ажилдаа явах, зорчих	3	6	24	30	34
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	202	196	97	65	24
Үүнээс:					
Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	167	163	73	43	13
Усанд явж, түлээ түлш бэлтгэх	22	21	14	14	5
<b>Ажлын 1 өдөр</b>	<b>264</b>	<b>297</b>	<b>326</b>	<b>349</b>	<b>368</b>
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	62	99	231	287	347
Үүнээс:					
Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	18	46	151	174	264
Орлого олох зорилгоор МАА эрхлэх	30	28	17	21	3
Ажилдаа явах, зорчих	3	7	25	33	40
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	202	198	95	62	22
Үүнээс:					
Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	168	164	73	42	12
Усанд явж, түлээ түлш бэлтгэх	21	21	13	13	4
<b>Амралтын 1 өдөр</b>	<b>268</b>	<b>275</b>	<b>290</b>	<b>280</b>	<b>187</b>
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	68	82	189	208	159
Үүнээс:					
Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	24	28	114	132	113
Орлого олох зорилгоор МАА эрхлэх	33	36	18	20	3
Ажилдаа явах, зорчих	3	4	20	21	19
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	200	193	102	71	29
Үүнээс:					
Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	163	159	75	48	15
Усанд явж, түлээ түлш бэлтгэх	23	23	16	16	7

Хүснэгт 4Б.4-т долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацааг хүйсээр болон хөдөлмөр эрхлэлтийн байдлаар харууллаа. Улсын дунджаар хөлстэй хөдөлмөрт долоо хоногийн 1 өдөрт зарцуулсан дундаж хугацаа хөдөлмөр эрхэлж буй



хүн амын хувьд 473 минут буюу 7.9 цаг байв. Харин хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд бага байх нь зүйн хэрэг бөгөөд 1 өдөрт зарцуулсан дундаж хугацаа 46 минут гарчээ. Өмнөх бүлэгт хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд хөлстэй хөдөлмөрт зарцуулсан хугацаа яагаад гарсан талаар дурдсан.

Нэг өдөрт хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй дундаж хугацаа хөдөлмөр эрхэлдэг эрэгтэйчүүдийн хувьд (519 минут) эмэгтэйчүүдтэй харьцуулахад (432 минут) 87 минут буюу 1.5 цагаар илүү байна. Хөлстэй хөдөлмөрөө задлан авч үзвэл эмэгтэйчүүд аж ахуйн нэгж, байгууллагад ажиллахад эрэгтэйчүүдээс илүү цагийг, харин мал аж ахуй эрхлэхэд бага цагийг зарцуулдаг байна.

Улсын дунджаар харахад хөдөлмөр эрхэлдэг хүн амын хувьд аж ахуйн нэгж, байгууллагад ажиллахад зарцуулсан хугацаа (213 минут) хөлстэй хөдөлмөрт зарцуулсан хугацааны (473 минут) бараг тал хувийг нь эзэлж байхад, өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэхэд (122 минут) дөрөвний нэг хугацааг нь зарцуулжээ.

Хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд хөлстэй хөдөлмөр зарцуулсан хугацааны дийлэнх хугацааг өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд (44 минут) зарцуулж байна.

Ажлын өдөр хөдөлмөр эрхэлдэг хүн амын хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй хугацаа амралтын өдөр зарцуулсан хугацаанаас бага гарах нь зүйн хэрэг юм. Харин хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд ажил, амралтын өдрөөр ялгаа багатай 45-49 минут байлаа.

Хүснэгт 4Б. 4. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, хөдөлмөр эхэлдэг эсэхээр, хүйсээр, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	Эрэгтэй		Эмэгтэй		Улсын дундаж	
	Хөдөлмөр		Хөдөлмөр		Хөдөлмөр	
	эрхэл-дэг	эрхэлдэг-гүй	эрхэл-дэг	эрхэлдэг-гүй	эрхэл-дэг	эрхэлдэг-гүй
<b>Долоо хоногийн 1 өдөр</b>	<b>519</b>	<b>67</b>	<b>432</b>	<b>37</b>	<b>473</b>	<b>46</b>
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	327	3	331	1	329	2
Үүнээс:						
Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	204	1	221	0	213	0
Орлого олох зорилгоор МАА эрхлэх	33	1	26	0	29	0
Ажилдаа явах, зорчих	33	0	36	0	35	0
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	192	64	101	36	144	44
Үүнээс:						
Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	169	28	80	13	122	17
Усанд явж, түлээ түлш бэлтгэх	14	22	13	13	13	16
<b>Ажлын 1 өдөр</b>	<b>544</b>	<b>64</b>	<b>471</b>	<b>37</b>	<b>505</b>	<b>45</b>
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	353	3	370	1	362	1
Үүнээс:						
Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	221	1	254	0	239	0
Орлого олох зорилгоор МАА эрхлэх	33	0	25	0	29	0
Ажилдаа явах, зорчих	37	0	41	0	39	0
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	191	61	101	36	143	43
Үүнээс:						
Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	169	27	81	12	123	17
Усанд явж, түлээ түлш бэлтгэх	13	21	12	13	13	15
<b>Амралтын 1 өдөр</b>	<b>454</b>	<b>73</b>	<b>328</b>	<b>39</b>	<b>387</b>	<b>49</b>
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	258	2	227	3	242	2
Үүнээс:						
Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	160	1	134	1	146	1
Орлого олох зорилгоор МАА эрхлэх	33	1	30	1	31	1
Ажилдаа явах, зорчих	24	0	24	0	24	0
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	196	71	101	36	145	46
Үүнээс:						
Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	169	30	78	14	121	19
Усанд явж, түлээ түлш бэлтгэх	16	25	15	14	16	17

Хүснэгт 4Б.5-д 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй цагийг хүйсээр болон үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, ажлын болон амралтын өдрөөр ялган харуулсан. Улсын дунджаар үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын хөлстэй хөдөлмөрт долоо хоногийн нэг өдөрт 178 минут зарцуулж байгаа нь үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амтай харьцуулахад 1.7 дахин бага байна. Энэ нь үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын хувьд хөлстэй хөдөлмөр эрхлэх боломж бие махбодын болон нийгмийн талаасаа бага байдагтай холбоотой байж болох юм.

Долоо хоногийн 1 өдөрт хөлстэй хөдөлмөрт үйлдлийн чадварын хүндрэлтэй эрэгтэйчүүд дунджаар 208 минут зарцуулж байхад үйлдлийн чадварын хүндрэлтэй эмэгтэйчүүдийн хувьд 51 минутаар бага хугацааг зарцуулж байна. Хөлстэй хөдөлмөрт хамаарах тусгайлсан үйл ажиллагаануудыг авч үзвэл үйлдлийн чадварын хүндрэлтэй эрэгтэйчүүдийн хувьд өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаанд (115 минут) илүү хугацааг зарцуулж байхад үйлдлийн чадварын

хүндрэлтэй эмэгтэйчүүдийн хувьд хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаанд (79 минут) илүү хугацааг зарцуулжээ.

Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын амралтын нэг өдөрт хөлстэй хөдөлмөрт зарцуулсан дундаж хугацаа ажлын нэг өдөрт зарцуулсан хугацаанаас 21 минутаар бага гарчээ.

Хүснэгт 4Б. 5. Долоо хоногийн, ажлын болон амралтын нэг өдөрт нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, хүйсээр, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	Эрэгтэй		Эмэгтэй		Улсын дундаж	
	Үйлдлийн чадварын хүндрэлгүй	хүндрэлтэй	Үйлдлийн чадварын хүндрэлгүй	хүндрэлтэй	Үйлдлийн чадварын хүндрэлгүй	хүндрэлтэй
<b>Долоо хоногийн 1 өдөр</b>	<b>395</b>	<b>208</b>	<b>259</b>	<b>157</b>	<b>315</b>	<b>178</b>
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	240	93	189	79	210	85
Үүнээс: Орлого олох зорилгоор МАА эрхлэх	23	30	15	5	19	15
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	155	115	71	77	105	93
Үүнээс: Өрхийн хэрэглээнд зориулж мал маллах	130	85	50	42	83	59
<b>Ажлын 1 өдөр</b>	<b>413</b>	<b>211</b>	<b>282</b>	<b>166</b>	<b>335</b>	<b>184</b>
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	259	99	211	89	231	93
Үүнээс: Орлого олох зорилгоор МАА эрхлэх	23	34	14	6	18	17
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	154	111	70	77	105	90
Үүнээс: Өрхийн хэрэглээнд зориулж мал маллах	130	83	50	41	83	58
<b>Амралтын 1 өдөр</b>	<b>349</b>	<b>203</b>	<b>201</b>	<b>132</b>	<b>261</b>	<b>162</b>
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	189	77	130	53	154	63
Үүнээс: Орлого олох зорилгоор МАА эрхлэх	24	20	17	5	20	11
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	159	126	71	80	107	99
Үүнээс: Өрхийн хэрэглээнд зориулж мал маллах	130	90	50	44	82	63

## В. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа

Дэлхийн хөгжлийн байгууллагууд хөлсгүй хөдөлмөрт цаг зарцуулж байгаа нь эдийн засгийн үйл ажиллагаанд орох нь зүйтэй гэдэг дээр хэлэлцүүлэг өрнүүлсээр байна. Тэр дундаа гэрийн ажил болон хүүхэд, өндөр настан, өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад зарцуулж буй цагийг илүү судалж Тогтвортой хөгжлийн зорилтын үзүүлэлтэд оруулсан билээ.

Хүснэгт 4В.1-д ТХЗ-ын үзүүлэлт 5.4.1-ийг сонгосон шинж байдлаар задлан үзүүлэв. Монгол Улсын хэмжээнд 12, түүнээс дээш насны хүн ам долоо хоногийн нэг өдөрт гэрийн ажилд дунджаар 155 минут, өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад 50 минут зарцуулдаг байна. Үүнийг нэгтгээд ТХЗ-ын 5.4.1-ийг тооцоход 205 минут буюу 3.4 цаг гарсан.

Хүснэгтээс харахад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс хөлсгүй хөдөлмөрт 2.6 дахин илүү хугацааг буюу 273 минутыг зарцуулж байна.

Бүсээр авч үзвэл Төвийн бүсийн (175 минут) хувьд уг үзүүлэлт хамгийн бага харин Улаанбаатар хотод (222 минут) хамгийн өндөр байна. Улаанбаатар хотын хүн амын хувьд өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад хамгийн их цаг буюу өдөрт 69 минут зарцуулж байгаа нь үүнд нөлөөлжээ.

Насны бүлгээр харахад 12-19 насныхан хөлсгүй хөдөлмөрт 115 минут буюу хамгийн бага хугацаа зарцуулж байхад 60, түүнээс дээш насныхан 236 минут буюу хамгийн их хугацааг зарцуулдаг нь харагдаж байна. Гэхдээ өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад зарцуулж буй цаг нь дээрх дүр зургаас бага зэргийн ялгаатай байв. Өөрөөр хэлбэл, 20-39 насныхан өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад бусдаас 41-58 минутаар илүү цагийг буюу нэг өдөрт 79-82 минут зарцуулж байна. 60, түүнээс дээш насны ахмадууд өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад өдрийнхөө 31 минутыг зарцуулдаг ч гэрийн ажилд 204 минутыг зарцуулж байгаатай уялдаад хөлсгүй хөдөлмөрт хамгийн их цагийг зарцуулж байна.

Боловсролын түвшин дээшлэх тусам хөлсгүй хөдөлмөрт зарцуулах хугацаа нэмэгдэж байгаа нь анхаарал татаж байв. Тодруулбал, бага боловсролтой хүн ам хөлсгүй хөдөлмөрт 153 минутыг зарцуулж байхад дээд боловсролтой хүн ам дунджаар 237 минутыг хөлсгүй хөдөлмөрт зарцуулдаг байна.

Хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй хугацааг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар авч үзэхэд хөдөлмөр эрхэлдэггүй хүн ам өдөрт дунджаар 304 минут буюу 5.1 цаг байхад хөдөлмөр эрхэлдэг хүн амын хувьд 2 дахин бага буюу ердөө 157 минут байна.

Үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр авч үзвэл ямар нэгэн үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүс гэрийн ажилд илүү цагийг буюу 188 минут (хүндрэлгүй 153 минут), харин өрхийн гишүүдийг асрахад бага цагийг буюу 36 минут (хүндрэлгүй 50 минут) зарцуулдаг байна. Энэ нь зарим тохиолдолд үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүс хүн асрахаас илүүтэйгээр өөрөө тусламж авах хэрэгцээ шаардлага байдагтай холбоотой байж болох юм.

Хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй хугацаа нь гэрлэлтийн байдлаар ялгаатай байв. Тодруулбал, огт гэрлээгүй хүмүүс хөлсгүй хөдөлмөрт гэр бүлтэй хүмүүстэй харьцуулахад ойролцоогоор 2 дахин бага буюу өдөрт дунджаар 134 минутыг зарцуулдаг байна. Харин ямар нэгэн байдлаар гэр бүлтэй буюу гэрлэсэн, хамтран амьдрагчтай эсвэл тусгаарласан, цуцалсан, бэлэвсэн тохиолдолд хөлсгүй хөдөлмөрт дунджаар 223-227 минутыг зарцуулжээ. Гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай хүн амын хувьд өдрийн 24 цагийнхаа 1 цагийг өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад зарцуулж байгаагийн дийлэнх нь хүүхэд асрахад зарцуулж байгаа цаг юм. Энэ талаар дараагийн хүснэгтүүдэд илүү тодорхой гарна.

Ажил, амралтын өдрөөр хөлсгүй хөдөлмөрийн ялгаатай байдлыг харахад ажлын өдөр өрхийн гишүүдийг асрахад, харин амралтын өдөр гэрийн ажилд илүү цаг зарцуулдаг байна.

Хүснэгт 4В. 1. Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын гэрийн ажилд болон өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад зарцуулж буй дундаж хугацаа, сонгосон шинж байдлаар, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд цалин хөлсгүй туслах	Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	Хөлсгүй хөдөлмөр [2]
<b>Улсын дүн</b>	<b>155</b>	<b>50</b>	<b>205</b>
<b>Хүйс</b>			
Эрэгтэй	83	25	107
Эмэгтэй	206	67	273
<b>Бүс</b>			
Баруун	160	35	195
Хангай	159	29	188
Төв	146	29	175
Зүүн	170	44	214
Улаанбаатар	153	69	222
<b>Байршил</b>			
Нийслэл	153	69	222
Аймгийн төв	160	41	201
Сумын төв	178	41	219
Хөдөө	142	21	162
<b>Насны бүлэг</b>			
12-19	94	21	115
20-29	141	82	223
30-39	148	79	227
40-49	147	38	185
50-59	182	32	214
60+	204	31	236
<b>Боловсролын түвшин</b>			
Боловсролгүй	143	26	169
Бага	134	20	153
Суурь	148	26	174
Бүрэн дунд	161	53	214
Техникийн болон мэргэжлийн	168	48	216
Дээд	157	79	237
<b>Хөдөлмөр эрхэлдэг эсэх</b>			
Хөдөлмөр эрхэлдэг	122	35	157
Хөдөлмөр эрхэлдэггүй	224	80	304
Мэдээлэл байхгүй [1]	89	23	112
<b>Үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэх</b>			
Хүндрэлгүй	153	50	204
Хүндрэлтэй	188	36	224
<b>Гэрлэлтийн байдал</b>			
Огт гэрлээгүй	110	24	134
Гэрлэсэн/ хамтран амьдрагчтай	163	60	223
Тусгаарласан/ цуцалсан/ бэлэвсэн	188	39	227
Мэдээлэл байхгүй [1]	89	23	112
<b>Ажлын болон амралтын өдөр</b>			
Ажлын өдөр	145	52	197
Амралтын өдөр	182	43	225

[1] Хөдөлмөр эрхлэлт болон гэрлэлтийн байдлыг 15, түүнээс дээш насны хүн амаас асуусан.

[2] ТХЗ-ын үзүүлэлт 5.4.1

Хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байгаа дундаж хугацааг сонгосон үзүүлэлтээр хүснэгт 4В.2-8-д харуулсан. Хөлсгүй хөдөлмөрт хамаарах хоол хүнс бэлтгэх, гэр, сууц, хашаагаа цэвэрлэх, хувцас гутал угаах, арчлах, хүүхэд асрах, хүүхдэд даалгавар хийхэд туслах, үлгэр ном уншиж өгөх, хамт тоглох, өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн гишүүн асрах зэрэг зарим үйл ажиллагааг нарийвчлан харуулсан.

Хүснэгт 4В.2-т хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байгаа дундаж хугацааг хүйс, байршлаар харууллаа. Үүнээс харахад гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд цалин хөлсгүй туслах, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулж буй дундаж хугацаа эмэгтэйчүүдийн хувьд төвөөс алслагдах тусам өсөх хандлагатай байхад эрэгтэйчүүдийн хувьд эсрэгээрээ байна.

Эмэгтэйчүүдийн хоол хүнс бэлтгэхэд, гэр сууц, хашаагаа цэвэрлэхэд болон хувцас, гутал угаах арчлахад зарцуулж буй дундаж хугацаа төвөөс алслагдах тусам нэмэгдэж байна. Тодруулбал, хотын эмэгтэйчүүд хоол хүнс бэлтгэхэд дунджаар 85 минут зарцуулж байхад хөдөөгийн эмэгтэйчүүд 127 минутыг зарцуулдаг байна. Эрэгтэйчүүдийн хувьд хоол хүнс бэлтгэхэд зарцуулж буй хугацаа нь байршлаар төдийлөн ялгаа багатай 23-32 минут байв.

Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад зарцуулж буй дундаж хугацаа нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд адилхан төвөөс алслагдах тусам багасаж байна. Хүүхэд асрах болон хүүхдэд анхаарал тавихад зарцуулж байгаа цаг дээрхтэй адил хандлагатай байгааг харж болно. Мөн өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад зарцуулж буй цагийн дийлэнх нь хүүхэд асрахад хамаарч байна.

Суурин газрууд болох нийслэл, аймгийн төв, сумын төвд амьдардаг хүн амын хувьд хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй дундаж хугацаа нь амралтын өдөр ажлын өдөртэй харьцуулахад их байхад хөдөөгийн хүн амын хувьд ялгаагүй байв.

Хүснэгт 4В. 2. Долоо хоногийн, ажлын болон амралтын 1 өдөрт хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан дундаж хугацаа, хүйс, байршлаар, минутаар, Монгол Улс, 2019 он

Үйл ажиллагаа	Нийслэл		Аймгийн төв		Сумын төв		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Долоо хоногийн 1 өдөр</b>	<b>136</b>	<b>288</b>	<b>138</b>	<b>267</b>	<b>134</b>	<b>294</b>	<b>68</b>	<b>264</b>
Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд цалин хөлсгүй туслах, үйлчилгээ үзүүлэх	89	191	97	204	95	235	57	225
Үүнээс:								
Хоол хүнс бэлтгэх	31	85	31	99	32	114	23	127
Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	25	56	26	52	31	71	18	66
Хувцас, гутал угаах, арчлах	7	28	6	31	7	34	3	23
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	37	88	25	52	24	53	6	35
Үүнээс:								
Хүүхэд асрах	32	80	21	47	20	47	6	33
Үүнээс: Хүүхдэд даалгавар хийхэд туслах, үлгэр, ном уншиж өгөх, хамт тоглох	8	16	6	9	6	11	2	6
Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	10	10	16	11	15	6	5	5
<b>Ажлын 1 өдөр</b>	<b>131</b>	<b>278</b>	<b>133</b>	<b>250</b>	<b>128</b>	<b>277</b>	<b>68</b>	<b>263</b>
Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд цалин хөлсгүй туслах, үйлчилгээ үзүүлэх	83	176	91	185	90	213	57	222
Үүнээс:								
Хоол хүнс бэлтгэх	30	82	30	93	32	110	23	128
Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	23	53	25	50	31	66	17	65
Хувцас, гутал угаах, арчлах	6	21	5	22	4	23	3	20
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	40	92	25	54	25	57	6	36
Үүнээс:								
Хүүхэд асрах	34	84	21	48	21	50	6	34
Үүнээс: Хүүхдэд даалгавар хийхэд туслах, үлгэр, ном уншиж өгөх, хамт тоглох	8	17	6	9	6	11	2	6
Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	9	10	17	11	13	6	5	5
<b>Амралтын 1 өдөр</b>	<b>150</b>	<b>315</b>	<b>150</b>	<b>309</b>	<b>148</b>	<b>339</b>	<b>68</b>	<b>267</b>
Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд цалин хөлсгүй туслах, үйлчилгээ үзүүлэх	107	231	110	252	108	290	57	232
Үүнээс:								
Хоол хүнс бэлтгэх	34	92	34	112	31	125	24	125
Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	30	64	28	58	31	83	20	69
Хувцас, гутал угаах, арчлах	12	46	10	57	12	62	3	29
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	30	75	24	47	21	43	7	32
Үүнээс:								
Хүүхэд асрах	27	70	19	45	18	41	7	30
Үүнээс: Хүүхдэд даалгавар хийхэд туслах, үлгэр, ном уншиж өгөх, хамт тоглох	9	15	7	9	6	9	2	5
Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	13	9	16	10	19	6	4	3

Хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийг насны бүлэг болон хүйсээр хүснэгт 4В.3-д харуулав. Нэг өдөрт гэрийн ажил хийхэд зарцуулж буй дундаж хугацаа нь насны бүлэг ахих тусам нэмэгдэж байв. Тодруулбал, долоо хоногийн нэг өдөрт гэрийн ажилд зарцуулж буй дундаж хугацаа 12-19 насныхны хувьд 94 минут, 20-49 насныхны хувьд 141-148 минут, 50-59 насныхны хувьд 182 минут, 60, түүнээс дээш насныхны хувьд 204

минут байна. Энэхүү дүр зураг нь хоол хүнс бэлтгэх, гэр, сууц, хашаагаа цэвэрлэх, хувцас, гутал угаах, цэвэрлэх зэрэг тусгайлсан үйл ажиллагааны хувьд ч ижил байгааг харж болно.

Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах үйл ажиллагаанаас хүүхэд асрах, тэр дундаа хүүхдэд даалгавар хийхэд туслах, үлгэр, ном уншиж өгөх, хамт тоглоход зарцуулж буй цагийг тусгайлан авч үзсэн. Хүүхэд асрахад 20-39 насны хүн ам долоо хоногийн 1 өдөрт дунджаар 73-75 минут зарцуулж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна. Хүүхдэд тусгайлан анхаарал тавьж, хөгжихөд нь дэмжлэг үзүүлэхэд зарцуулж буй цаг харьцангуй бага буюу 5-16 минут байгааг анхаарах хэрэгтэй. Энэхүү үзүүлэлт нь тухайн нэг хүний хувьд тооцсон цаг тул хэд хэдэн хүүхэд байгаа тохиолдолд 1 хүүхдэд зарцуулсан дундаж хугацаа бүр бага болно.

Амралтын өдөрт хөлсгүй хөдөлмөрт илүү их цаг зарцуулж байгаа хэдий ч ажлын болон амралтын өдрийн ялгаатай байдал нь хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй цагийн ялгаатай байдалтай харьцуулахад бага байв.



